

Монгол Улс дахь уул уурхайн дэд салбар - бичил уурхай

ГАРЧИГ

Нэгдүгээр бүлэг. Бичил уурхай дэлхий дахинд	3
1.1. Бичил уурхайн тухай зарим тоо баримт.....	4
1.2. Бичил уурхайтай холбоотойгоор бий болсон үр дагаварууд	4
1.3.Олон улсад бичил уурхайн салбарыг дэмжсэн эрх зүйн зохицуулалтууд.	6
Хоёрдугаар бүлэг. Монгол Улсын бичил уурхайн салбарын хөгжлийн өнөөгийн байдал.....	8
2.1. Монгол Улсын уул уурхайн салбарын хөгжил.	8
2.2. Монгол Улсад хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааны үүсэл.	10
2.3. Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааны хууль эрх зүйн орчин.	12
Гуравдугаар бүлэг . Хувиараа ашигт малтмал олборлож буй иргэдийн хүн ам зүйн шинж байдал	15
3.1. Хувиараа ашигт малтмал олборлогчдын тоо:	15
3.2 Хувиараа ашигт малтмал олборлогчдын нас, хүйс.	17
3.3. Хувиараа ашигт малтмал олборлогчдын харьяалал, шилжилт хөдөлгөөн.	17
3.4.Хувиараа ашигт малтмал олборлогчдын боловсролын түвшин:	18
3.5. Хувиараа ашигт малтмал олборлогчдын гэр бүлийн байдал.	19
3.6. Хувиараа ашигт малтмал олборлогчдын өрхийн ам бүлийн байдал.	20
3.7. Насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөр эрхлэлт	21
3.8. Хувиараа ашигт малтмал олборлогчдын ажил эрхлэлт	21
3.9. Бичил уурхай ба жендерийн асуудал.	22
Дөрөвдүгээр бүлэг. Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн олборлож буй ашигт малтмалын нэр төрөл, борлуулалтын зах зээл,	22
4.1.Алт олборлолт:	23
4.2.Алтын борлуулалтын зах зээл.....	26
4.3. Жонш олборлолт.....	27
4.4.Жонш борлуулалт:	28
4.5.Нүүрс олборлолт:	29
Тавдугаар бүлэг . Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшин.....	30
5.1.Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн орлого.....	30
5.2. Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн зарлага.	31
5.3. Хувиараа ашигт малтмал олборлогчдын амьжиргааны түвшин.	32
Зургадугаар бүлэг . Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн эрүүл мэнд, нийгмийн даатгал, хүн амын орлогын татвар төлөлт.....	33
6.1.Эрүүл мэндийн байдал ба эрүүл мэндийн тусламж үйлчилгээ.	33
6.2. Нийгмийн даатгал, нийгмийн халамж	35
6.3. Хүн амын орлогын албан татвар төлөлт.	36
Долдугаар бүлэг. Хувиараа ашигт малтмал олборлогчдын ажлын байрны нөхцөл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, гэмт хэрэг, зөрчил	37
7.1. Хувиараа ашигт малтмал олборлогчдын ажлын байрны нөхцөл.	37
7.2. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа.....	Error! Bookmark not defined.
7.3. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчсөнөөс гардаг осол аваар.....	39

7.3. Хувиараа ашигт малтмал олборлохтой холбоотой гэмт хэрэг, зөрчил	41
Наймдугаар бүлэг . Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн бүтэц зохион байгуулалтанд орж буй хэлбэрүүд.....	42
8.1. Бүтэц зохион байгуулалтын хэлбэрүүд.....	42
8.2. Харилцаа холбоо	44
8.3. Хамтын ажиллагаа ба төрийн бус байгууллагуудын бүтэц зохион байгуулалт	45
Есдүгээр бүлэг . Орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд бичил уурхайн оруулж буй хувь нэмэр	46
Аравдугаар бүлэг . Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа ба байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл.....	48
10.1.Байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл.	48
10.2.Хувиараа ашигт малтмал олборлолт ба нөхөн сэргээлт.	51
Арваннэгдүгээр бүлэг . Хувиараа ашигт малтмал олборлогчдын хөгжил, цаашдын чиг хандлага.	52
АШИГЛАСАН ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ	57

Нэгдүгээр бүлэг. Бичил уурхай дэлхий дахинд

Дэлхийн хэмжээнд эрдэс баялгийн түүхий эдийн эрэлт хэрэгцээ өсч, ашигт малтмалын олборлох, боловсруулах үйлдвэрүүд нэмэгдэж, нөөцийн хэмжээ улам бүр хомсдож байгаа өнөөгийн нөхцөлд ашигт малтмалын нөөцийг бүрэн гүйцэд ашиглах шаардлага тулгарч байгаа билээ. Энэ асуудлыг шийдвэрлэх үйлсэд дэлхийн олон улс оронд үүсэн бий болсон цагаасаа хойш 100 гаруй жилийг ардаа орхисон Бичил уурхай чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн юм.

Хэдийгээр аливаа улс орны эрдэс баялагийн нөөц нь эдийн засгийнхаа өсөлтийг хангах, ядуурлыг бууруулах бодлого хийгээд тухайн улсын тогтвортой байдал болон тогтвортой хөгжлийн үндэс суурь гэдэг боловч заримдаа эрдэс баялаг ихтэй орнууд ч хөгжлийн доройтол, ядуурал, хээл, хахууль болон иргэний тэмцэл зөрчилдөөнд хурцаар нэрвэгдэх байдал ажиглагдаж байна.

Гэхдээ бичил уурхай, хувиараа ашигт малтмал олборлолтоос үүсэн буй болж байгаа эдийн засгийн хүчин зүйлсийг үнэлж олон улс орон холбогдох хууль гаргах, бичил санхүүгийн үйл ажиллагаа явуулах, сертификат буюу эрдэс баялгийн гарал үүслийн бичиг олгож хууль ёсны худалдааг дэмжих зэрэг бололцоотой бүхий л хэлбэрээр бичил уурхайн хөгжлийг дэмжихийг зорьж байгаа ажээ. Бичил уурхай хөгжсөн улс орнуудын эрх зүйн зохицуулалтыг судалж үзэхэд, дийлэнх улс орон Уул уурхайн хуулиндаа бичил уурхайн тухай асуудлуудыг тусгаж өгсөн байх бөгөөд Гана, Филиппин, Перу зэрэг орон Бичил уурхайн тухай тусгай хууль гарган хэрэгжүүлж байна.

1.1. Бичил уурхайн тухай зарим тоо баримт

Өнөөдөр дэлхийн 55 оронд нийт 50 орчим сая хүн бичил уурхайд ажиллаж байгаагаас 30 гаруй хувь нь эмэгтэйчүүд, 8 хувь нь хүүхдүүд байгааг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын гаргасан судалгаагаар тогтоосон. Эдгээр бичил уурхай эрхлэгчдийн гэр бүл болох 100-150 сая гаруй хүн амьдралаа бичил уурхайгаас залгуулдаг ажээ. Тэдгээрийг улс орноор нь авч үзвэл:

Ази, Номхон далайн орнуудад	17 сая хүн
Африк тивийн орнуудад	10 сая хүн
Латин Америкийн орнуудад	5 сая хүн
Хөгжиж байгаа орнуудад	15 сая хүн

Дэлхийн алт, мөнгөний үйлдвэрлэлийн 10 хувь, зэсийн 8 хувь, цайрын 11 хувь, өнгөт чулуу 100 хувь, хайлуур жоншны 90 хувь, түгээмэл ашигт малтмалын 30 хувь бичил уурхайд ноогдож байна. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

Ашигт малтмалын төрөл	Дэлхийд эзлэх хувь
Алт	10
Мөнгө	10
Зэс	8
Цайр	11
Хайлуур жонш	90
Өнгөт чулуу	100
Элс хайрга	30

1.2. Бичил уурхайтай холбоотойгоор бий болсон үр дагаварууд

Хүн төрөлхтөн өсөхийн хэрээр хоол хүнсний хэрэгцээ, хэрэглээ нэмэгдэж, түүнийгээ хангах үүднээс эмзэг, хуурай газрыг хэт их ашиглан газрын доройтол, цөлжилт үүсгэсний уршгаар газраас олох орлого буурч, ядуурал нэмэгдэж байна.

Бичил уурхай бүхий улсуудын нийгэм, эдийн засгийн хөгжил, засаглалаас шалтгаалан тухайн орны нийгэмд эерэг, сөрөг үзэгдлүүд бий болдог. Хэдийгээр бичил уурхайн хөгжил улс орон бүрт харилцан адилгүй байгаа боловч тухайн орны нийгэм эдийн засгийн хөгжилд уг салбар сөрөг үзэгдлүүдээс илүүтэйгээр эерэг үр дагавруудыг авчирдаг байна. Тухайлбал:

Ажлын байр бий болгох



Орон нутгийн хөгжлийг дэмжих



Ядуурлыг бууруулах

Шинэ үйлчилгээний бизнесүүдийг хөгжүүлэх



Засгийн газрын ачааг хөнгөвчлөх

Шинэ технологи

Хувь хүний өөртөө итгэх итгэлийг бэхжүүлэх



Бие биедээ туслах



Эв нэгдэл



Хөдөлмөрөөрөө хоршиж ажиллах




Харилцан илтгэлцлийг бий болгох

Ардчилал, шударга ёс

Өөрсдийн эрхийг хамгаалах чадвар эзэмших

Бичил уурхай бүхий улс орнуудад түгээмэл тохиолдож буй асуудлуудыг хүснэгтлэн харуулбаас:



1.3.Олон улсад бичил уурхайн салбарыг дэмжсэн эрх зүйн зохицуулалтууд.

Хөгжиж буй улс орнууд иргэдийнхээ амьд явах, хөдөлмөрлөх эрхийг хангах хүрээнд бичил уурхайн салбарыг дэмжих, шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг хийх санал, санаачлага гарган, зохих оролдлогуудыг хийж иржээ. Эдгээр санал, санаачлагуудаас хамгийн их анхаарал татаж буй нь ядуурлыг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэхэд бичил уурхайг чиглүүлэн тогтвортой амьжиргаа, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хэрэгжүүлж буй бодлого юм.

Бичил уурхайн салбар хөгжиж буй улс орнуудын төр захиргааны байгууллагуудаас баримтлаж ирсэн бодлогын өөрчлөлт, хөгжлийг дараах үе шатуудад хувааж үзэх боломжтой байна. Үүнд:


Үе шатууд	Бичил уурхайн талаарх бодлогын үндсэн хандлага
1970-аад он	Хүлээн зөвшөөрөх эсэх, бичил уурхайг хэрхэн тодорхойлох
1980-аад он	Техникийн асуудал
1990-ээд оны	Техникийн, байгаль орчны, хууль эрх зүйн, нийгмийн болон эдийн засгийн

эхэн үе	асуудлуудыг нэгтгэх
1990-ээд оны дунд үе	Бичил уурхайн бие даасан хууль гаргахад онцгой ач холбогдол өгч эхэлсэн
1990-ээд оны сүүл үе	Уул уурхайн компани ба бичил уурхайн харилцаа, жендер, хүүхдийн хөдөлмөрийн асуудал
2000 он	Тогтвортой амьжиргаа, орон нутгийн хөгжлийг дэмжих

Олон улсад бичил уурхайн салбарыг дэмжсэн эрх зүйн зохицуулалт хийхдээ дараах асуудлуудад онцгой анхаарал тавьжээ. Үүнд:

- Эрдэс баялгийн нөөцийн ашиглалтыг удирдан зохион байгуулах асуудал хариуцсан нэгжийг бий болгох.
- Салбарын хөрөнгө оруулалтыг дэмжих
- Ашиглалтын талбайг лицензжүүлэх, хариуцлагажуулах, хяналтанд оруулах
- Бичил уурхайн хэвийн үйл ажиллагааг хуульчлах

Харин Олон улсын бичил уурхайчдын нийгэмлэгээс бичил уурхайн салбар хөгжиж буй улс орнуудад дөрвөн тулгуур багана бүхий бодлого хэрэгжүүлэхийг уриалдаг. Энэхүү дөрвөн тулгуур багана бүхий бодлого нь:



1. Ядуурлыг бууруулахад бичил уурхайг чиглүүлэх:

- Бичил уурхайгаас тогтвортой хувь хишиг хүртэхийн тулд Засгийн газрын байгууллагууд, бичил уурхай эрхлэгчид, орон нутгийн байгууллагуудын хүчин чармайлтыг нэгтгэж, уялдуулан зохицуулах

2. Хуулийн дагуу хувиараа ашигт малтмал олборлогчдын бизнесийн нөхцлийг сайжруулах:

- Хууль зохицуулалтын орчинг бүрдүүлэх
- Хууль ёсны үйл ажиллагааг урамшуулах механизм бий болгох
- Сургалт, зөвлөгөө өгөх, туршлага нэвтрүүлэх үйлчилгээг үзүүлэх

3. Тогтвортой байдлыг хангах:

- Байгаль орчин, хөдөлмөрийн болон эрүүл ахуй, аюулгүй байдлын нөхцлийг хангаж эрсдэлийг бууруулах
- Ашигт малтмалын салбарт сайн засаглал хэрэгжүүлэх буюу хууль дүрмийг сахин биелүүлэх

4. Макро эдийн засаг, санхүүгийн дэглэмийг тогтворжуулах:

- Татварын орлогыг бүрдүүлэх тогтвортой найдвартай тогтолцоо **буй болгох**
- Ашигт малтмалын бүтээгдэхүүнээр нэмүү өртөг үйлдвэрлэлийг дэмжих

- Хар захаас зайлсхийх

Хоёрдугаар бүлэг. Монгол Улсын бичил уурхайн салбарын хөгжлийн өнөөгийн байдал.

2.1. Монгол Улсын уул уурхайн салбарын хөгжил.

Ашигт малтмал нь дэлхийн бүх өнцөг буланд жигд, элбэг тархдаггүй. Монгол орны газар зүйн байршлын онцлог, буянт дээдсийн маань хишиг, бид бүхний аз түшиж ашигт малтмалуудын арвин их нөөц манай орны нутаг дэвсгэрт заяажээ.

Монгол Улсын уул уурхайн салбар нь аж үйлдвэрийн хүрээнд төдийгүй манай орны нийт эдийн засагт зонхилох байр суурийг эзэлдэг гол салбаруудын нэг билээ. Өнгөрсөн 17 жилийн дотор Монгол Улсын алтны үйлдвэрлэл асар хурдацтай хөгжиж, бараг 30 дахин нэмэгдсэн байна. Энэхүү үсрэнгүй хөгжилд 1990-ээд оны дунд үеэс хэрэгжиж эхэлсэн “Алт” хөтөлбөр жинтэй хувь нэмэр оруулснаас гадна гадаадын хөрөнгө оруулалтын үр дүнд 2008 онд алт үйлдвэрлэлтийн хэмжээ 15,21 тоннд хүрсэн байна.

Монгол Улсын ДНБ-д тус салбар 2002 онд 10 хувийг эзэлж байсан бол сүүлийн 5 жилд 3 дахин нэмэгдэж 2008 оны байдлаар 28,2 хувьд хүрчээ. Мөн уул уурхайн салбар 42 мянга гаруй (буюу нийт ажиллах хүчний 4 гаруй хувь) хүнийг ажлын байраар хангаж, Монгол улсын экспортын нийт орлогын ¼-аас илүүг бүрдүүлж байна.

Ашигт малтмалын орд газар гэсэн ойлголтонд хүн төрөлхтний тухайн үеийн техник, эдийн засгийн хөгжлийн түвшинд ашиглахад үр ашгаа өгөхүйц байгалийн тогтоц, ашигт элементүүдийг бүрдүүлэгчийг хуримтлуулсан геологийн тогтоцыг хамааруулж болно. Харин ашигт малтмалын нөөц гэдэг нь тухайн орд газар буюу түүний тодорхой хэсэгт байгаа ашигт малтмалын нийт хэмжээг илэрхийлдэг.

Албаны эх сурвалжийн мэдээгээр манай орны нутаг дэвсгэрт 80 гаруй нэр төрлийн 1200 гаруй орд, 8000 гаруй илэрцийг тогтоогоод байгаа ажээ.

2010 оны 11-р сарын 1-ний байдлаар:

Тусгай зөвшөөрлийн нэр төрөл	Тоо хэмжээ	Талбайн хэмжээ
Хайгуулын	3048	25,7 сая га
Ашиглалтын	1149	520,9 мян. га

Дээр дурдсанчилан нийт 4197 лицензийг олгоод байгаа нь манай орны нутаг дэвсгэрийн 16,7 хувийг эзэлж байна. Эдгээр 4197 лицензийн 2971-ийг нь дотоодын 1500 аж ахуйн нэгжүүд (Засгийн газар саяхан цуцалсан 254 лиценз, цаашид цуцлахаар төлөвлөж байгаа 1700 лицензийн ихэнх нь энэ хэсэгт орж байгаа), 859 лицензийг гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай 264 аж ахуй нэгжүүд, 368 лицензийг хамтарсан хөрөнгө оруулалттай 152 аж ахуй нэгжүүд тус тус эзэмшиж байна.

Мөн манай орны өдөр тутмын хэвлэлүүдэд мэдээлснээр 2010 оны 9-р сарын эхний байдлаар лиценз эзэмшигчдийг бүртгэгдсэнээр нь авч үзвэл:

Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн харьяалал	Тусгай зөвшөөрлийн тоо
Англи	443
ОХУ	248
БНХАУ	232

Канад	76
БНСУ	70
Япон	141
Бермуд	156
Багами	98
Шинэ Зеланд	36
Барбадос	30

Эндээс үзвэл, манай орон газар нутгийн хувьд том, ашигт малтмалын арвин нөөцтэй, харьцангуй чөлөөт, либерал эрх зүйн зохицуулалттай тул уул уурхайн хөрөнгө оруулагчдыг ихээхэн татаж чадсан болох нь харагдаж байна.

Уул уурхайн хөрөнгө оруулагчид нь олгосон лицензийн хүрээнд эрэл, хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаа явуулах бүх зардал, эрсдэлийг өөрсдөө үүрч, түүндээ тохирсон техник технологи, ноу- хауг оруулж ирэн, ажлын байр бий болгож, дотоодын зах зээлээс хоол хүнс, бусад хэрэгцээт зүйлсээ голчлон худалдан авч, тодорхой хугацаагаар бидэнтэй хамт амьдарч, манай эдийн засагт дэмжлэг үзүүлэн, манай улс, ард түмний сайн, мууг гадарлах болсон хүмүүс байдаг нь сүүлийн арав гаруй жилийн туршлагаас харагддаг юм.

Хэрэв аз таарч, ашигтай нөөц илрүүлвэл тухайн газар орны төдийгүй, улс гүрний үнэ цэнийг үлэмж нэмэгдүүлэхийн зэрэгцээ илрүүлсэн ашигт малтмалаа олборлох замаар гаргасан зардлаа нөхдөг бөгөөд манай улс тэдэнд үүрсэн эрсдэлээсээ давсан ашиг олохыг зөвшөөрөхийн хамт юм олсон эсэхийг нь үл харгалзан тэдний эзэмшиж байгаа талбайн хэмжээ, хугацаанаас нь хамааруулаад төлбөр авч, сэвтээсэн талбайн хэсгийг нь нөхөн сэргээлгэдэг. Хэрэв ашигт малтмал олборлох тохиолдолд байгаль орчинд үзүүлж болох хохирлын үнэлгээг хийлгэж, олсон орлогоос нь татвар авдаг бөгөөд хэрэв хуульд заасан үндэслэл бүрдсэн гэж үзвэл олгосон зөвшөөрлийг нь цуцалж болдог бөгөөд энэ нь дэлхийн ихэнх оронд байдаг нийтлэг практик тул учиргүй их сандарч бухимдах үндэслэл багатай юм. Сүүлийн хоёр жилийн хугацаанд 1680 орчим лицензийг эзэмшигчээс нь хуулийн дагуу улс хураан авчээ.

Монгол Улсын 2009 оны статистикийн эмхэтгэлд дурдсан үзүүлэлтүүдээс үзэхэд манай улсын экспортын нийт бүтээгдэхүүний дийлэнхийг буюу 2009 оны байдлаар 84,6 хувийг нүүрс, зэс, төмөр, цайр, хайлуур жонш зэрэг боловсруулаагүй буюу хагас боловсруулж баяжуулсан түүхий ашигт малтмал эзэлж, цаашид ч улам нэмэгдэхээр байгаа ажээ.

Монгол Улсын уул уурхайн экспортын гол нэрийн бараа

	2006 он	2007 он	2008 он	2009 он
Нүүрс мян. тн	2380,0	3269,0	4169,3	7113,2
Боловсруулаагүй нефть мян. барр.	337,9	812,3	1058,9	1938,5
Боловсруулсан, хагас боловсруулсан бүтээгдэхүүн				
Зэсийн баяжмал мян. тн	599,5	607,8	582,9	587,0
Молибдений баяжмал мян. тн	3,3	3,2	4,1	6,7
Жоншны баяжмал мян.тн	355,0	360,0	348,8	314,0
Тунгаасан зэс, хайлш мян.тн	2,4	3,2	2,6	2,3
Хагас боловсруулсан алт тн	15,4	11,6	22,1	10,9
Цайрын баяжмал мян.тн	105,8	132,6	137,5	150,7

Уул уурхайн олборлох үйлдвэрлэлийн салбарын аж ахуйн нэгж байгууллагын тоо:

	2006 он	2007 он	2008 он	2009 он
Аж ахуйн нэгж байгууллага	529	628	695	722

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо

	2006 он	2007 он	2008 он	2009 он
Аж ахуйн нэгж байгууллага	305	312	347	323

Хэдийгээр уул уурхайн салбар асар хурдацтай хөгжих ирээдүй харагдаж байгаа боловч албан ёсоор гаргадаг статистик мэдээллүүдэд бичил уурхайн дэд салбарын олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн талаарх мэдээлэлийг орхигдуулсан хэвээр байгаа нь харагдаж байгаа болно. Ядуурлыг бууруулах, орон нутгийн хөгжлийг дэмжихэд бичил уурхайг чиглүүлэх бодлогыг төрөөс баримтлаж байгаа бол тэдгээрийг хариуцлагажуулах үүднээс үйлдвэрлэлийнх нь талаарх бодит тоо, мэдээллийг албан ёсны статистик мэдээллүүдэд хамааруулах шаардлагатай юм.

2.2. Монгол Улсад хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааны үүсэл.

Монгол Улсад ашигт малтмалыг хувиараа олборлох үйл ажиллагаа нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг бүхий социалист систем задарч, зах зээлийн харилцаанд шилжиж эхэлсэн он жилүүдэд эдийн засгийн бүтцийн өөрчлөлт хийх үед гарч ирсэн ажилгүйдэл, мөнгөний ханшны уналт, хүн амын бодит орлогын бууралт зэрэг сөрөг үр дагаварын хариуд бий болсон үзэгдэл юм.



Тухайлбал шилжилтийн эхний жилүүдэд 5000 гаруй ажиллагсадтай байсан Налайхын их уурхай хаагдахад тус уурхайд үе дамжин ажиллаж ирсэн уурхайчид ажилгүйчүүдийн эгнээнд шилжсэн билээ. Ийнхүү ажил, амь зуулгаасаа салсан уурхайчид амьдрахын эрхээр хууль бусаар нүүрс олборлож эхэлсэнээр хувиараа ашигт малтмал олборлох анхны үйл ажиллагаа эхэлсэн гэж зарим хүмүүс үздэг. 1990-ээд оны үед олон үйлдвэр, үйлчилгээний газрууд үүд хаалгаа барьсанаас ажилгүй болсон ажилчид, түүнчлэн манай оронд хэд хэдэн жил дараалан тохиолдсон ган зудад нэрвэгдэж малгүй болсон иргэд 1990-ээд оны үед хувиараа ашигт малтмал идэвхитэйгээр олборлох болсон билээ.

Швейцарийн Хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төслөөс захиалан Баянхонгор аймгийн Жаргалант, Төв аймгийн Борнуур, Өвөрхангай аймгийн Уянга, Говь-Алтай аймгийн Бигэр сумдад явуулсан нийгэм, эдийн засгийн суурь судалгааны дүгнэлтээс үзэхэд судалгаанд оролцогчдын дийлэнх нь дундажаар 6,2 жилээс доошгүй хугацаанд хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа эрхэлж байгаа гэсэн дүгнэлт гарчээ.

Мөн хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа эрхэлж буй хугацаагаар нь авч үзсэн үзүүлэлтүүдийг дээрх судалгаануудаас түүвэрлэн үзэхэд:

- Оролцогчдын 10,2 хувь нь 10-15 жил,

- Оролцогчдын 6,5 хувь нь 15-18 жил хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд оролцож байгаа гэсэн хариулт өгсөн байна.

Эдгээр хариултууд нь Монгол Улсад хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааны үүсэл 1992 оноос эхтэй гэж үзэх үндэслэлтэйг харуулж байгаа юм.

Уул уурхайн салбарын судлаачид болон эдийн засагчид Монгол Улсад бичил уурхай үүссэн шалтгааныг:

1. Шилжилтийн үйл явцтай холбоотой
 - шилжилтийн стратеги
 - эдийн засгийн гадаад орчин, чадавхи
 - хүн амын ажилгүйдэл
 - ядуурал
2. Байгалийн гамшиг, зуд
 - малгүй болсон иргэд
 - үйлдвэрлэлд ажиллаж байгаад ажилгүй болсон ажилтнууд
3. Ашигт малтмалын нөөцийн орд, илэрцийн геологийн өвөрмөц тогтоц
4. Уул уурхайн олборлох аж ахуйн нэгжүүдийн хариуцлагагүй үйл ажиллагаа зэрэг хүчин зүйлсүүдтэй холбон үзэж тайлбарласан байдаг.

Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа эрхлэх болсон шалтгаануудыг нэгээс дээш сонголт бүхий давхардсан байдлаар хариулт өгсөн үзүүлэлтээс харахад судалгаанд оролцогчдын 76,6 хувь нь орлого олох өөр боломж байхгүй тул амьжиргаагаа залгуулах, 69,3 хувь нь ажлын байргүйгээс, 35,0 хувь нь зуданд малаа алдаж малгүй болсон тул, 24,9 хувь нь хүүхдийн сургалтын төлбөр төлөх, 19,1 хувь нь амьдрах орчин нөхцлөө сайжруулах, 17,6 хувь нь өр зээлээ төлөх зорилгоор гэж тодорхойлжээ. Эдгээр шалтгаанууд нь эдийн засагчид, судлаачдын тодорхойлсон хүчин зүйлсүүдийг улам тодотгож өгч байгаа болно. Нөгөө талаар манай улсын орон нутгийн хөгжил, ажилгүйдэл, ядуурлын түвшин ямар хэмжээнд байгааг илтгэж байна гэж үзэж болохоор юм.



Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдэд олон төрлийн асуудлууд тулгарч байдаг ч тэдгээрийг дараахи байдлаар ерөнхийлөн ангилж үзэж болно. Үүнд:

- 2008 оны 2-р сард Засгийн газраас түр журам батлан гаргахаас өмнөх хууль бус үйл ажиллагаа;
- боловсронгуй бус технологи хэрэглэж ирсэн учраас эдийн засгийн хувьд үр ашиггүй, байгаль орчинд ээлгүй, нийгмийн асуудал нь тогтворгүй, хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагаа;
- байгалийн нөөц ашиглалттай холбоотой гардаг зөрчлүүд

2.3. Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааны хууль эрх зүйн орчин.



Бичил уурхайг хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд хөгжүүлж чадсан тохиолдолд олон тооны ажлын байр бий болох, ажилгүйдэл ядуурал буурах, хөдөөгийн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах нөөц боломж их байдаг. Монгол Улсын Засгийн газар бичил уурхайтай холбоотой хэд хэдэн чухал эрх зүйн акт, журмыг өнгөрсөн хугацаанд батлан хэрэгжүүлж ирсэн байна. Үүнд:

1. Хувиараа алт олборлогч иргэдийн үйл ажиллагааг зохицуулах тухай Монгол улсын Засгийн газрын 28-р тогтоол.
2. Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр
3. Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам, Монгол улсын Засгийн газрын 72-р тогтоол

Эдгээр тогтоол, журмуудыг гарган мөрдүүлснээр хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа бичил уурхайн хэлбэрт шилжих, бичил уурхайн олборлолт, техник технологийн тухай асуудлууд шийдэгдэж эхэлсэн байна. Ингэснээр хувиараа алт олборлогч иргэдийн хамтын ажиллагааны зохион байгуулалт, орлогын эх үүсвэр болон ажлын байрны баталгаажилт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, нийгмийн бусад харилцааг зохицуулахад нааштай өөрчлөлтүүд гарсаар байна.

Монгол Улсын Засгийн газраас баталсан “Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам” хэрэгжээд багагүй хугацаа өнгөрснийг харгалзан уг түр журмын хэрэгжилтэнд 2009 оны 1-р сард Ашигт малтмалын газар, Швейцарийн хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төсөл хамтран үнэлгээ хийжээ.

Хувиараа ашигт малтмал олборлогч 104 иргэн, 60 гаруй сумын засаг дарга нарыг оролцуулан мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийсний эцэст гаргасан уг үнэлгээнээс үзвэл хувиараа ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагаа, бичил уурхай эрхлэх газрын асуудлыг энэхүү журмаар зохицуулах боломжгүй, хууль эрх зүйн өөр зохицуулалт шаардлагатай гэсэн дүгнэлт гарчээ.

Тиймээс бичил уурхайн салбарт улам боловсронгуй, амьдралд нийцсэн, бодитойгоор хэрэглэгдэхүйц бөгөөд хэрэгжихүйц хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага тулгарч байна.

Үүнийг харгалзан Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2009 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 107 дугаар тушаалаар “Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ыг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэлтэй зарим асуудлыг шийдвэрлэх, түүний эрх зүйн орчин бүрдүүлэх талаар санал боловсруулах ажлын хэсэг байгуулжээ. Улмаар ажлын хэсгийн гишүүд ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг журмаар зохицуулах, журмыг Засгийн газар батлах, орон нутаг өөрөө бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд газар авдаг эрхтэй байхаар зохицуулалт хийх нь зүйтэй гэсэн нэгдсэн дүгнэлтэнд хүрсэн тул “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулсан байна.

“Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг дараах үзэл баримтлалд тулгуурлан боловсруулсан байна. Үүнд:

- Бичил уурхайн зориулалтаар олгох газрыг нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага сонгож, энэ газрын талаар геологи уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрсөн дүгнэлт гарсан тохиолдолд ашигт малтмал олборлох гэрээ байгуулах өргөдөл гаргасан нөхөрлөлүүдэд гэрээгээр ашиглуулах,
- Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох иргэд Иргэний хуулийн 481-д заасны дагуу хамтран ажиллах гэрээний үндсэн дээр бүртгэгдээгүй нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдаж үйл ажиллагаа явуулах

Энэхүү хуулийн төсөлтэй хамт “Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай”, “Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулиудын төсөл, түүнчлэн түр журамд үнэлгээ хийх явцад хувиараа ашигт малтмал олборлогчид болон төр захиргааны байгууллагын ажилтнуудын гаргасан санал, зөвлөмж, дүгнэлт дээр тулгуурлан “**Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журм**”-ын төслийг боловсруулжээ.

Улсын Их Хурлаар 2010 оны 07 дугаар сарын 01-ний өдөр “**Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай**”, “**Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай**”, хуулиуд тус тус батлагдсан байна.

Дээр дурдсан хуулийн төслүүд батлагдсанаар иргэд хувиараа ашигт малтмал олборлосноос үүсээд байгаа нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаваруудыг бууруулах нөхцөл бүрджээ гэж үзэж болохоор байна. Тухайлбал:

Нийгмийн үр дагавар:

- Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэд тухайн орон нутагт бүртгэлтэй болж, эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдсанаар төр засгаас үзүүлж байгаа эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээг хүртэх боломжтой болох,
- Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааны эрх зүйн үндэс бүрдэж, ашигт малтмалын хууль бус худалдааг хязгаарлаж, гэмт хэрэг, зөрчлийн тоо буурах,
- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг мөрдөж ажилласнаар эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөл бүрдэнэ.

Эдийн засгийн үр дагавар:

- Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох иргэд баталгаатай ажлын байраар хангагдаж, орлогын эх үүсвэртэй болон, амьжиргааны түвшингээ дээшлүүлэх нөхцөл бүрдэнэ.
- Орон нутагт ажлын байр нэмэгдэн, ажилгүйчүүдийн тоо буурч, Засгийн газрын хөтөлбөрт тусгагдсан ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зорилтыг хэрэгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулна.
- Бичил уурхайгаар ашигт малтмал олборлож байгаа иргэд хөдөөгийн хөгжилд хувь нэмэр оруулж, улмаар орон нутгийн төсвийн орлого нэмэгдэнэ.

Манай Улсын бичил уурхайн салбарт 2007 оноос хойш хамгийн өргөн хүрээтэй, үр дүнтэй ажиллаж байгаа төсөл бол Швейцарийн хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төсөл юм.



Тогтвортой бичил уурхай төслийн үндсэн шат хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурах ёслолын ажиллагаа, 2007.05.02, Улаанбаатар хот.

Энэхүү төслийн зорилго нь Монгол Улсад хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэх чиглэлээр холбогдох талуудтай хамтран ажиллаж, бичил уурхай эрхлэгчдийг хөдөөгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулдаг нийгмийн хариуцлагатай гишүүд болгоход туслалцаа үзүүлэхэд оршдог. Дээрх зорилгын хүрээнд уг төсөл нь:

- Бичил уурхайн салбарт ил тод, шударга бодлого, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудлыг боловсруулан, хэрэгжүүлж эхлэх,
- Бичил уурхайн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг бүх түвшинд бий болгож ажиллах,
- Бичил уурхай эрхлэгчдийг ашигтай, хариуцлагатай уул уурхай эрхлэх, улмаар бизнесийн үйл ажиллагаа явуулах чадвартай болгох,
- Бичил уурхай эрхлэгчид болон бусад нөөц ашиглагчдыг экологи, нийгмийн асуудалд хариуцлагатай хандаж, болзошгүй аливаа зөрчлийг шийдвэрлэх чадвартай болоход нь дэмжлэг үзүүлэхийг зорьж байна.

Тус төслийн нэгдүгээр бүрэлдэхүүн хэсэг болох **“Бичил уурхайн салбарт ил тод, шударга бодлого, эрх зүй, зохицуулалтын орчин бүрдүүлэх”** ажлын хүрээнд УИХ, Монгол Улсын Засгийн газар, холбогдох төрийн байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа, хувиараа ашигт малтмал олборлогчид, тэдгээрийн үүсгэл санаачлагын төрийн бус байгууллагуудтай хамтран бүх түвшинд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулжээ.

Бичил уурхайн хууль эрх, зүйн орчинг сайжруулах, бодлогын баримт бичгүүдийг бий болгоход идэвхитэй туслалцаа, дэмжлэг үзүүлж, холбогдох талуудтай үр нөлөөтэй хамтран ажилласны үр дүнд **“Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, “Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай”** хуулиуд батлагдаж, улмаар “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг Засгийн газраас батласан байна.

Гуравдугаар бүлэг . Хувиараа ашигт малтмал олборлож буй иргэдийн хүн ам зүйн шинж байдал

3.1. Хувиараа ашигт малтмал олборлогчдын тоо

Монгол Улсын суурин хүн амын тоо 2009 оны жилийн эцсийн байдлаар 2735,8 мянга болж өмнөх оныхоос 52,3 мянган хүн буюу 1,9 хувиар өссөн байна. “Ажиллах хүчний судалгаа”-ны дүнгээр 2009 онд эдийн засгийн идэвхитэй 1137,9 мянган хүн байгаагаас 1006,3 мянга буюу 88,4 хувь нь ажиллагчид, 131,6 мянга буюу 11,6 хувь нь ажилгүй иргэд байна. Ажиллагчдыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд 34,7 хувь нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, ан ба загас агнуурын салбарт, 15,9 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 7,4 хувь нь боловсролын салбарт, 6,8 хувь нь тээврийн ба агуулахын үйл ажиллагааны салбарт, 6,2 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 3,4 хувь нь уул уурхай, олборлолтын салбарт ажиллаж байгаа ажээ.

Уул уурхайн дэд салбар болох бичил уурхайд АМГ-ын гаргасан судалгааны мэдээллээс үзэхэд 2008 оны байдлаар 53,9 мянган иргэн хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж байсан бол 2009 оны байдлаар тэдгээрийн тоо **42,3** хувиар буурч 35124 болсон бөгөөд 2010 онд өмнөх оноос **36,5** хувиар өсч 61000 хүн болжээ.

Харин олон улсын байгууллагуудын гаргасан судалгаагаар 100 гаруй мянган иргэн хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд оролцож байгаа гэсэн дээрхээс зөрүүтэй мэдээлэл байдаг бөгөөд эдгээр судалгаануудын дүн ийнхүү зөрүүтэй гарч байгаа нь хувиараа ашигт малтмал олборлогчид өөрсдийнхөө талаар мэдээлэл өгөх сонирхол бага, улирлын чанартай шилжилт хөдөлгөөн их, орон нутгийн засаг захиргааны зүгээс бүртгэл тооллого явуулах нөхцөл боломж дутмаг байдагтай холбоотойгоор тайлбарлаж болох юм.

Хувиараа ашигт малтмал олборлогчдын тооны талаарх судалгаа. (2006-2010 он)

№	Аймаг, орон нутгийн нэр	Судалгаа гаргасан огноо				
		2006.02.20	2007.05.15	2008.01.05	2009.08.01	2010 он
1	Архангай	4050	700	-	127	200
2	Баянхонгор	10000	24400	5200	7675	5680
3	Баян-Өлгий	300	620	620	25	200
4	Булган	600	600	-	138	300
5	Говь-Алтай	2340	5050	2340	2581	29000
6	Дархан-Уул	750	1430	1180	160	1100
7	Дорноговь	2090	3353	1180	516	1730
8	Дундговь	2200	550	820	160	180
9	Завхан	16	20	15	15	20
10	Өвөрхангай	30500	15700	15000	19200	12000
11	Өмнөговь	1340	3556	15540	548	300
12	Сүхбаатар	85	82	52	-	-
13	Сэлэнгэ	1550	1550	1730	1710	1560
14	Төв	8800	900	3200	702	1800
15	Увс	5430	4890	1290	-	560
16	Ховд	126	200	126	548	450
17	Хэнтий	840	1050	3840	120	2200

18	Хөвсгөл		28	150	649	2380
19	Дорнод			200	153	240
20	Налайх дүүрэг	1800		1476	914	1100
	Нийт дүн	72817	64679	53959	35124	61000

Эх сурвалж: АМГ

Дээрх тоон мэдээллээс үзэхэд 2006 оноос хойш хувиараа ашигт малтмал олборлогчдын тоо буурсан мэт харагдаж байгаа боловч энэ нь олон хүнд итгэл үнэмшил төрүүлэхүйц тоо байж чадахгүй юм.

Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд. (Хувиар)

	Ядууралд өртөгсдийн хүрээ			Ядуурлын гүнзгийрэлт		
	2006 он	2007-2008 он	2009 он	2006 он	2007-2008 он	2009 он
Улсын дундаж	32,2	35,2	38,7	10,1	10,1	10,6
Хот	27,9	26,9	30,6	8,6	7,7	7,8
Хөдөө	37,0	46,6	49,6	11,9	13,4	14,4

Эх сурвалж: Монгол улсын Статистикийн эмхтгэл. 2009 он

Статистик үзүүлэлтүүдээс үзэхэд хөдөөгийн ядууралд өртөгсдийн хүрээ 2006 онд хөдөөд 37 хувь, ядуурлын гүнзгийрэлт 11,9 хувь байсан бол 2009 онд ядууралд өртөгсдийн хүрээ 49,6 хувь, ядуурлын гүнзгийрэлт 14,4 хувь болж тус тус нэмэгджээ.

Зөвхөн эдгээр үзүүлэлтүүдээс үзэхэд манай орны ялангуяа хөдөөгийн хүн амын ажилгүйдэл, ядуурал дээрх хугацаанд багасаагүй, харин ч нэмэгдсэн байгаа тул хувиараа ашигт малтмал олборлогчдын тоон судалгаа чухамдаа бодит бус байгааг харуулж байна.

Зарим тоо баримтаас...

- Говь-Алтай аймагт хувиараа алт олборлох үйл ажиллагаа эрс идэвхижсэн 2009 оны 7-11дүгээр сарын хооронд алт олборлогчдын тоо хамгийн их болсон буюу давхардсан тоогоор 65 мянга гаруйд хүрчээ.
- 2010 оны 1 дүгээр сарын байдлаар тус аймгийн 11 сумын 22 цэгт, нийт 615 га талбайд 29047 иргэн хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж байсан байна.

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн Бодлогын Хэлтэс

Нөгөө талаар уул уурхайн салбарын албан болон албан бус хөдөлмөр эрхлэлтийг харьцуулж үзэхэд тус салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчид 2006 онд нийт ажиллагсдын 63,5 хувийг, 2007 онд 59,5 хувийг, 2008 онд 53,7 хувийг, 2009 онд 50,2 хувийг тус тус эзэлж байсан нь хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааны цар хүрээ хэр их байгааг харуулж байгаа юм.

Монгол Улсын уул уурхайн салбарын албан ба албан бус хөдөлмөр эрхлэлтийн байдал.

Он	Уул уурхайн салбарын албан ёсоор хөдөлмөр эрхлэгчдийн тоо	Бичил уурхайн салбарт хувиараа ашигт малтмал олборлогчдын тоо
2006	41900	72817
2007	44100	64679
2008	46500	53959
2009	34800	35124
2010		61000

3.2 Хувиараа ашигт малтмал олборлогчдын нас хүйс

Монгол Улсын хүн амын хүйсийн харьцааг 2009 оны жилийн эцсийн байдлаар авч үзвэл нийт хүн амын 48,9 хувь нь эрэгтэйчүүд, 51,1 хувь нь эмэгтэйчүүд байв. Үүнээс үзвэл, хүйсийн харьцааны үзүүлэлт буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 96 байв.

Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд хамрагдаж байгаа иргэдийн нас, хүйсийн харьцааг үнэн бодиттойгоор тодорхойлох боломжгүй юм. Хэдийгээр байдал ийм байгаа ч “Тогтвортой бичил уурхай” төслийн захиалгаар 2009, 2010 онд хийгдсэн орон нутагт дахь хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн нийгэм, эдийн засгийн суурь судалгаагаар дараах үзүүлэлт гарч ирсэн байна.

Хувиараа ашигт малтмал олборлогчдын хүйсийн харьцаа

Байршил	Хувиараа ашигт малтмал олборлолтонд эрэгтэйчүүдийн эзэлж буй хувь	Хувиараа ашигт малтмал олборлолтонд эмэгтэйчүүдийн эзэлж буй хувь
Өвөрхангай аймаг, Уянга сум	67,4	32,6
Төв аймаг, Борнуур сум	68,0	32,0
Говь-Алтай аймаг, Бигэр сум	76,6	23,3
Баянхонгор аймаг, Жаргалант сум	65,5	34,5
Дундаж хувь	69,4	30,6

Дээрх судалгааны үзүүлэлтүүд нь хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд оролцогчдын **69,4** хувь нь эрэгтэйчүүд, **30,6** хувь эмэгтэйчүүд эзэлж байгааг харуулж байна. Хүйсийн харьцааг нь үзвэл 1 эмэгтэй тутамд 2,3 эрэгтэй ноогдож байна. Энэ нь хувиараа ашигт малтмал олборлох ажил нь харьцангуй хүнд нөхцөлтэй учир эрэгтэйчүүдийн оролцоо давамгайл байгаатай холбоотой.

Хувиараа ашигт малтмал олборлогчдыг насны бүтцээр нь авч үзвэл 36-гаас дээш насны эрэгтэйчүүд, 26-35 хүртэлх насны эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин харьцангуй өндөр байна.

3.3. Хувиараа ашигт малтмал олборлогчдын харьяалал, шилжилт хөдөлгөөн.

Хүн амын чөлөөтэй шилжилт хөдөлгөөн нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан эрхийн нэг бөгөөд иргэн бүр улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, нийгмийн амьдралд чөлөөтэй оролцох, нийгмийн суурь тусламжийг хүртэх эрхтэй.

Энэхүү эрхийн хүрээнд хүн амын дотооддоо шилжих хөдөлгөөний асуудлыг Үндсэн хууль, иргэний бүртгэл, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хууль болон бусад холбогдох хууль эрх зүйн баримтуудаар зохицуулдаг.

Орон нутагт хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд тухайн сумын иргэдээс гадна бусад аймаг, сумын иргэд оролцож байгаа билээ.

Тухайн үед мөрдөгдөж байсан “Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын 5.22-т нөхөрлөлийн гишүүдэд тавигдах шаардлагыг заасан байдаг бөгөөд тухайлбал, уг журмын 22.1.-д Монгол улсын иргэн байх, 22.2.-т 18 нас хүрсэн байх, 22.3.-т тухайн орон нутагт байнга оршин суугчаар бүртгүүлсэн байх гэж тус тус заажээ.

Дээр дурдсан заалтуудын хүрээнд хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд оролцож байгаа иргэдийн бүртгэлжүүлэлтийн асуудлыг 2009, 2010 онд хийсэн судалгааны үр дүнгээс үзэхэд дараах байдалтай байна.

Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн харьяалал

Үзүүлэлт	Бигэр сум сум	Борнуур сум	Жаргалант сум	Уянга сум
Судалгаанд хамрагдсан хувиараа ашигт малтмал олборлогчдын дунд орон нутгийн бүртгэлтэй оршин суудаг иргэдийн эзлэж буй хувь	7,8	93,0	89,2	18,0
Өөр аймаг сумын буюу бүртгэлгүй хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн эзлэж буй хувь	92,2	7,0	10,8	82,0

Төв аймгийн Борнуур, Баянхонгор аймгийн Жаргалант суманд хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд оролцож буй иргэдийн 89,2-93 хувийг нь тухайн орон нутгийн иргэд бүрдүүлж байгаа нь Монгол Улсын Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэр, журмуудыг хэрэгжүүлэх талаар орон нутгийн төр захиргааны байгууллага, хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн санаачлага, хариуцлагатай ажиллагаатай шууд холбоотой. Нөгөө талаар эдгээр сумд нь ТоБУТ хэрэгжсэн газрууд бөгөөд хувиараа ашигт малтмал олборлогч иргэдэд хууль эрх зүйн орчны талаар мэдлэг ойлголт өгөх, бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж, нийгмийн хариуцлагатай гишүүд болон төлөвших чиглэлд арга зүйн туслалцаа үзүүлэх, тэдгээрийг орон нутгийн засаг захиргаа болон тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй харилцан ойлголцох, гэрээ байгуулахад нь дэмжлэг үзүүлэх зэрэг төслийн зүгээс үе шаттайгаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн юм.

Харин Говь-Алтай аймгийн Бигэр, Өвөрхангай аймгийн Уянга сумдын хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд оролцож буй иргэдийн 82,0-92,2 хувийг өөр аймаг сумдын буюу тухайн орон нутагт бүртгэлгүй иргэд эзэлж байгаа нь тухайн орон нутгийн засаг захиргааны санаачлага, хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн ухамсар, нийгмийн хариуцлага зэрэгтэй холбож тайлбарлаж болох ч нөгөө талаар энэ нь өрөөсгөл дүгнэлтэд хүргэж болох талтайг ч үгүйсгэх аргагүй.

Иргэд нийгмийн суурь тусламж үйлчилгээг хүртэхэд иргэний бүртгэлийн бичиг баримтууд зайлшгүй шаардлагатай байдаг. Хувиараа ашигт малтмал олборлогчид иргэний бүртгэлд хамрагдаагүй, бичиг баримтгүйгээс болж ажиллаж буй орон нутгаасаа эрүүл мэнд, нийгмийн тусламж үйлчилгээг хүртэхэд өөрсдийгөө хүндрэлтэй байдалд оруулдаг ажээ.

3.4.Хувиараа ашигт малтмал олборлогчдын боловсролын түвшин.

Бичил уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг хувиараа ашигт малтмал олборлогчдын боловсролын түвшин нь харилцан адилгүй, дийлэнх тохиолдолд ажлын байргүй, эмзэг давхаргын хүмүүс байдаг тул бүрэн хэмжээгээр судлаж тогтооход хүндрэлтэй бөгөөд өмнө нь энэ талаар нарийвчлан явуулсан судалгаа бараг байхгүй байна. Хувиараа ашигт малтмал олборлогчдын нийгэм эдийн засгийн суурь судалгааны үр дүнгээс үзэхэд тэдгээрийн боловсролын түвшин дараах байдалтай байна.

Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн боловсролын түвшин (хувиар)

Боловсролын түвшний үзүүлэлт	Бигэр сум	Борнуур сум	Жаргалант сум	Уянга сум	Дундаж хувь
------------------------------	-----------	-------------	---------------	-----------	-------------

Боловсролгүй	7,2	2,0	8,7	5,8	5,9
Бага боловсролтой	11,4	8,0	21,6	20,2	15,3
Бүрэн бус дунд боловсролтой	25,7	37,0	41,2	44,3	37,05
Бүрэн дунд боловсролтой	40,4	28,0	23,8	24,4	29,2
Тусгай дунд ба дээд боловсролтой	15,3	25,0	4,7	5,3	12,6
	100	100	100	100	

Бичиг үсэгт тайлагдсан байдлын улсын дундаж 97,6 хувьтай байгааг Монгол Улсын 2008 оны статистикийн эмхтгэлд дурджээ.

Харин нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 94,1 хувь нь бичиг үсэг мэддэг, 5.9 хувь нь бичиг үсэг мэддэггүй байгаа нь хувиараа ашигт малтмал олборлогчдын бичиг үсэгт тайлагдсан байдал нь улсын дундажаас 3,4 хувиар бага байна.

Дээрх хүснэгтээс үзэхэд судалгаанд хамрагдсан нийт хувиараа ашигт малтмал олборлогчдын 37,05 хувийг бүрэн бус дунд боловсролтой иргэд, 29,2 хувийг бүрэн дунд боловсролтой иргэд, 15,3 хувийг бага боловсролтой иргэд, 12,6 хувийг тусгай болон дээд боловсролтой иргэд, 5,9 хувийг боловсролгүй иргэд тус тус эзлэж байгаа ажээ.

Судалгаанд хамрагдагсдын дотор бүрэн дунд боловсролтой иргэд нэлээд өндөр хувийг эзэлж байгаагаас үзвэл ерөнхий боловсролын сургууль төгссөнийхөө дараа их, дээд сургууль, коллежуудад элсэн орж чадаагүй залуус хувиараа ашигт малтмал олборлогчдын дунд олон байна гэж дүгнэх үндэс болж байна. Нөгөө талаар энэ нь ашигт малтмал олборлосноор залуу хүмүүст богино хугацаанд бэлэн мөнгө олох харьцангуй илүү боломж гардагтай холбоотой юм.

Мөн нийт судалгаанд оролцогчдын 37,05 хувь нь бүрэн бус дунд боловсролтой байгаа нь тэд хувиараа ашигт малтмал олборлохтой холбоотой хууль эрх зүйн орчныг ойлгох, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлах, дагаж биелүүлэх чадамжтай гэж дүгнэх боломж олгож байна.

3.5. Хувиараа ашигт малтмал олборлогчдын гэр бүлийн байдал.

Манай орны хувьд нийт 34,1 мянган хос 2009 онд гэрлэлтээ бүртгүүлж, 2,4 мянган гэр бүл гэрлэлтээ цуцлуулжээ. Нөгөө талаар 1000 хүнд ноогдох гэр бүл цуцлуулалт 2006 оноос аажмаар өсч, 2009 онд 0,9 болж өмнөх оныхоос 0,2 пунктээр нэмэгдсэн байна. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо 2009 онд 81,2 мянга болж 2006 оныхтой харьцуулахад 12,4 хувь, 2007 оныхоос 12,6 хувь, 2008 оныхоос 5,8 хувиар тус тус өссөн байна.

Орон нутагт хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг иргэд гэр бүл, найз нөхдийн хүрээнд албан бус зохион байгуулалттайгаар эрхэлдэг гэсэн албан бус судалгаа байдаг. Хэдийгээр энэ нь албан бус мэдээлэл боловч нийгэм эдийн засгийн суурь судалгааны үр дүнгээс үзэхэд тэдгээрийн гэр бүлийн байдал дараах байдалтай байгаа нь тогтоогдож байна.

Хувиараа ашигт малтмал олборлогчдын гэр бүлийн байдал (хувиар)

Гэрлэлтийн байдал	Бигэр сум	Борнуур сум	Жаргалант сум	Уянга сум	Дундаж хувь
Огт гэрлээгүй	15,3	12	13,5	21,0	15,5
Гэр бүлтэй	77,0	78	68,5	55,5	69,7
Салсан, тусгаар-ласан, бэлэвсэн	7,7	10	18,0	23,5	14,8
	100	100	100	100	

Судалгаанд хамрагдсан хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн **69,7** хувь нь гэр бүлтэй, **15,5** хувь нь огт гэрлээгүй, **14,8** хувь нь гэрлэлтээ цуцлуулсан, бэлэвсэн, олон сар жилээр гэр бүлээсээ тусгаарласан байна. Энэхүү судалгаанаас үзэхэд олон жил хууль бусаар алт олборлох үйл ажиллагаа явагдсан Өвөрхангай аймгийн Уянга сумын судалгаанд оролцогч иргэдийн хувьд **21,0** хувь нь огт гэрлээгүй, **23,5** хувь нь салсан, тусгаарласан, бэлэвсэн гэсэн үзүүлэлтэд багтаж байгаа нь анхаарал татаж байна.

Нийгэм эдийн засгийн суурь судалгааны үр дүнгээс үзэхэд хувиараа ашигт малтмал олборлогчдын **30,6** хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд тэдгээрийн дотор 26-35 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин харьцангуй өндөр гарч байгаа нь бичил уурхайг зохицуулах талаар төрөөс баримтлаж байгаа бодлогын хүрээнд хүн амын нөхөн үржихүйн болоод хүүхдийн эрүүл мэнд, боловсролын талаарх асуудлыг анхаарах шаардлагатай байгааг харуулж байгаа юм.

3.6. Хувиараа ашигт малтмал олборлогчдын өрхийн ам бүлийн байдал.

2009 оны байдлаар Монгол Улсын нийт өрхийн тоо 716,5 мянга, түүний 61,5 хувь нь хотод, 38,5 хувь нь хөдөөд байгаа бөгөөд улсын дундажаар нэг өрхөд 3,8 хүн ноогдож байна. Хөдөө орон нутагт ажилгүйдэл, ядуурлаас шалтгаалан олон иргэд хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд татагдан орж байгаа нь бодит үнэн билээ.

Бичил уурхайн дэд салбарт үйл ажиллагаа явуулдаг хувиараа ашигт малтмал олборлогчдын өрхийн ам бүлийн байдлыг нийгэм эдийн засгийн суурь судалгааны үр дүнд тулгуурлан авч үзэхэд дараах байдалтай байгаа болно.

Өрхийн ам бүлийн тоо (хувиар)

Үзүүлэлт	Бигэр сум	Борнуур сум	Жаргалант сум	Уянга сум	Дундаж
1-3 гишүүнтэй	29,1	28,0	13,0	28,0	24,5
4 гишүүнтэй	35,7	52,0	49,5	34,5	42,9
5-8 гишүүнтэй	35,2	20,0	37,5	37,5	32,6
Ам бүлийн дундаж тоо	4,35	4,5	4,6	5	4,6

Судалгаанд хамрагдсан хувиараа ашигт малтмал олборлогч нийт өрхийн **42,9** хувийг 4 гишүүнтэй өрх, **32,6** хувийг 5-8 гишүүнтэй өрх, **24,5** хувийг 1-3 гишүүнтэй өрх тус тус эзэлж байв. Сумаар нь авч үзвэл Борнуур сумын хувиараа ашигт малтмал олборлогчдын 52,0 хувийг 4 гишүүнтэй өрх эзэлж байгаа бол Уянга сумын хувиараа ашигт малтмал олборлогчдын 37,5 хувийг 5-8 гишүүнтэй өрх эзэлж байгаа нь өндөр үзүүлэлт юм. Эдгээр үзүүлэлт нь хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд гэр бүлийн дийлэнх гишүүд хамрагдаж байгаагийн нотолгоо байж болох юм.

Тухайлбал, Уянга сумын судалгаанд хамрагдсан иргэдийн 35,0 хувь нь гэр бүлийнхээ хамт Өлтийн хөндийд амьдардаг бөгөөд нэг гэр бүл дундажаар 5 гишүүнтэй гэсэн үзүүлэлт гарч байгаа бөгөөд үүнээс үүдэн хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа нь урт удаан хугацаанд **гэр бүлээрээ** ажиллах нөхцөлийг бүрдүүлдэг гэж үзэх болохоор байна. Нөгөө талаар бусад иргэдийн хувьд найз нөхөд, хамаатан садан, хамтран амьдрагчтайгаа нийлж “нэг гал” болон нэг гэр, оромж, дуганцагт 6-12-уулаа амьдарч байгаа болохыг тогтоосон. Энэ тохиолдол нь гэр бүл салах, гэр бүлээсээ удаан хугацаагаар хөндийрөх, гэр бүлийн амьдрал зохиохоос зайлсхийх зэрэг нөхцлүүдийг бүрдүүлдэг байж болохоос гадна ариун цэвэр, эрүүл ахуйн маш хүнд нөхцөлд амьдарч байгааг харуулж байна.

Хувиараа ашигт малтмал олборлогчдын ам бүлийн дундаж тоог сонирхож үзэхэд **4,6** байгаа нь улсын дунджаас даруй 0,8 хүнээр илүү байна.

Хэрвээ хувиараа ашигт малтмал олборлогчдын өрхийн дундаж ам бүлийн тоог **4,6** гэж үзвэл 2010 оны байдлаар 61.0 мянган хувиараа ашигт малтмал олборлогчид үйл ажиллагаа явуулж

байгаа нь тэдгээрийн ар гэр болох 208,600 хүний ахуй амьдрал бичил уурхайгаас шууд хамааралтай гэсэн үг юм.

3.7. Насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөр эрхлэлт

Хэдийгээр Монгол Улс хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийг даруй устгах арга хэмжээ авахыг шаардсан Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенцийг соёрхон баталсан боловч олон арван хүүхэд өрх гэрийн орчин нөхцөл, ядуурал, ажилгүйдлээс шалтгаалан хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд гар бие оролцож байна.

Улсын хэмжээнд хамгийн олон иргэд цугларч, хууль бусаар алт олборлох үйл ажиллагаа эрхлэж байсан, одоо ч хувиараа ашигт малтмал олборлогчдынх нь тоо төдийлөн цөөрөхгүй байгаа сумыг бид сонгон аваад хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг судлаж үзсэн юм.

Өвөрхангай аймгийн Уянга сумын хэмжээнд хүүхдийн хөдөлмөр эрхлэлт

№		Үзүүлэлт	Тоо	эрэгтэй	эмэгтэй
1	Нийт хөдөлмөр эрхэлдэг		109	80	29
2	Үүнээс	Сургуульд сурдаг	53	42	11
		Сургууль завсардсан	56	38	18
3	Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийг салбараар нь авч звэл	Уул уурхайн салбарт	67	51	16
		Хөдөө аж ахуйн салбарт	39	26	13
		Айлд зарцлагдаж буй	3	3	

Дээрх хүснэгтээс харахад тус суманд хөдөлмөр эрхэлж байгаа нийт хүүхдийн **61,4** хувь нь уул уурхайд, 35,7 хувь нь хөдөө аж ахуйд, 2,7 хувь нь айлд зарцлагдаж байгаа бөгөөд тэдгээрийн 73,4 хувийг эрэгтэй, 26,6 хувийг эмэгтэй хүүхэд эзэлж байгаа ажээ. Мөн уул уурхай дахь хөдөлмөр эрхлэлтийг хүйсийн хувьд авч үзвэл 76,1 хувийг эрэгтэй, 23,9 хувийг эмэгтэй хүүхэд эзэлж байна.

Уул уурхайн хүнд хүчир хөдөлмөрт хүүхдүүд гар бие оролцож байгаа нь ар гэр нь ядуу зүдүү, эцэг эх нь хөдөлмөрийн чадваргүй, ар гэр нь таагүй уур амьсгалтай зэргээс хамааралтай бөгөөд нөгөөтэйгүүр үүнийг гэр бүл салалт, архидалт зэрэг олон хүчин зүйлтэй холбон үзэж болно. Гэхдээ хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр эрхлэлт уул уурхайн салбараас гадна бусад салбаруудад ч гэсэн байсаар байгаа нь ойлгомжтой юм.

3.8. Хувиараа ашигт малтмал олборлогчдын ажил эрхлэлт

Монголын ард түмний нэг хэсэг болсон маш олон хүн төр засгаас гуйлга гуйлгүйгээр байгаль цаг уурын таагүй нөхцлийг үл хайхран хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хувьд өндөр эрсдэлтэй байдаг хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг эрхэлж амь зуулгаа залгуулж байгаа билээ.

Хувиараа ашигт малтмал олборлогчдын ажил эрхлэлтийг тэдгээрийн дунд явуулсан нийгэм эдийн засгийн судалгааны үр дүнг үндэслэн тодорхойлбол:

Хувиараа ашигт малтмал олборлогчдын ажил эрхлэлт (хувиар)

Үзүүлэлт	Бигэр сум ХАМО	Борнуур сум ХАМО	Жаргалант сум ХАМО	Уянга сум ХАМО	Дундаж хувиар
Алт олборло-хоос өөр ажил	32,0	68,0	53,0	78,0	57,8

эрхэлдэггүй					
Өөр ажил давхар эрхэлдэг	68,0	32,0	47,0	22,0	42,3

Гарсан үр дүнгүүдийг нэгтгэж үзвэл судалгаанд хамрагдсан нийт хувиараа ашигт малтмал олборлогчдын **57,8** хувь нь алт олборлохоос өөр ажил эрхэлдэггүй, **42,3** хувь нь өөр давхар ажил эрхэлдэг болох нь харагдаж байгаа боловч алтнаас бусад ашигт малтмалын нэр төрөл, олборлолттой холбоотойгоор авч үзвэл энэ үзүүлэлт өөрчлөгдөхийг үгүйсгэх аргагүй.


Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд оролцогсдын дотор давхар хөдөлмөр эрхлэх явдал байгаагаас үзвэл бага цалинтай болон улирлын чанартай ажил хөдөлмөр эрхэлдэг хүмүүс, төсвийн зарим ажилчид, газар тариалан эрхлэгчид, сүүлийн жилүүдэд болсон ган, зудаас болж малынх нь тоо толгой эрс цөөрсөн малчид орлогоо нэмэгдүүлэх зорилгоор хувиараа алт олборлодог нь дээрх үзүүлэлтүүд болон судалгааны явцад хийсэн, ярилцлага, бүлгийн хэлэлцүүлгийн үеэр тодорхой болсон юм.

Мөн судалгаанд хамрагдсан хүмүүсийн 43 хувь нь хувиараа ашигт малтмал олборлох ажлыг 5-10 жилийн хугацаанд эрхэлж байгаа болон энэ ажлыг эрхэлсэн дундаж хугацаа нь 6,2 жил байгааг тогтоосон болно.

3.9. Бичил уурхай ба жендерийн асуудал.

Шилжилтийн үеийн эдийн засгийн хөгжлийн эхний үед эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн бие даасан байдал нилээд хэмжээгээр хязгаарлагдаж байжээ. Тухайлбал, улсын өмчийн үйлдвэр аж ахуйн газрууд хаагдах юм уу, орон тоогоо цөөлөх үед эмэгтэйчүүд хамгийн эхэнд халагдах тохиолдлууд элбэг байв. Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд оролцож буй эмэгтэйчүүдийн тэгш эрх, жендерийн асуудал хүндрэлтэй байдаг. Ялангуяа ашигт малтмалын олборлолтын бүтээгдэхүүний борлуулалтын орлого хуваарилах, хөдөлмөрийн хуваарилалт зэрэгт эмэгтэйчүүдийн эрхийг зөрчих, тэднийг гадуурхах, цалин хөлсийг нь багаар тогтоох, ажлын байран дээр дарамтлах, ашигт малтмал олборлож байгаа талбай болон олборлосон алтыг нь булаах, залилах зэрэг зөрчлүүд хувиараа ашигт малтмал олборлогчид зохион байгуулалтанд ороогүй байгаа газруудад гарсаар байна. Харин бүртгэгдээгүй нөхөрлөл байгуулан орон нутгийн засаг захиргаатай гэрээ байгуулан ажиллаж байгаа газруудад дээр дурдсан зөрчлүүд буурч, жендерийн тэгш байдал хангагдаж эхэлж байна гэж үзэх боломжтой юм.

Дөрөвдүгээр бүлэг. Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн олборлож буй ашигт малтмалын нэр төрөл, борлуулалтын зах зээл



2010 оны байдлаар хувиараа ашигт малтмал олборлогчдын **89,8** хувь нь алт, **3,6** хувь гянтболд, **3,8** хувь нь жонш, **1,8** хувь нь нүүрс, **0,5** хувь нь элс хайрга, **0,3** хувь нь гөлтгөнө, **0,2** хувь нь давс, цагаан шүр, гялтгануур зэрэг ашигт малтмалыг олборлож байна.

Бичил уурхайд олборлож буй ашигт малтмалын нэр төрөл, олборлогчдын тоо

	Ашигт малтмалын нэр төрөл	2006.02.20-ны байдлаар	2007.05.15-ны байдлаар	2008.01.05-ны байдлаар	2009 он	2010 он
1	Алт	65645	59292	48905	29790	54760
2	Гянтболд	310	630	632	2061	2200
3	Нүүрс	2163	1850	1719	914	1100
4	Гялтгануур	88	0	8	8	80
5	Жонш	3945	3602	2270	1856	2300
6	Элс хайрга	250	250	150	300	300
7	Гөлтгөнө	300	193	160	160	160
8	Давс	96	342	95	15	80
9	Цагаан шүр	20	20	20	20	20
	Дүн	72817	64679	53959	35124	61000

Хувиараа ашигт малтмал олборлогч нийт иргэдийг олборлож буй ашигт малтмалынх нь нэр төрлөөр авч үзвэл 2010 оны байдлаар хувиараа ашигт малтмал олборлогчдын **89,8** хувь нь алт, **3,8** хувь хайлуур жонш, **3,6** хувь нь гянтболд, **1,8** хувь нь нүүрс, **0,5** хувь нь элс хайрга, **0,3** гөлтгөнө, **0,1** хувь нь давс, **0,1** хувь нь гялтгануур, **0,03** хувь нь цагаан шүр олборлож байна. Харин 2009 оны байдлаар хувиараа ашигт малтмал олборлогчдын 84,8 хувь нь алт, 5,9 хувь нь гянтболд, 5,3 хувь нь хайлуур жонш, 2,6 хувь нь нүүрс, 0,8 хувь нь элс хайрга, үлдсэн 0,6 хувь нь давс, гөлтгөнө, цагаан шүр, гялтгануур зэрэг ашигт малтмалыг олборлож байгаа болохыг АМГ-аас гаргасан мэдээлэлд дурджээ.

2007 оноос хойш хувиараа ашигт малтмал олборлогчдын тоо буурсан харагдаж байгаа шалтгаан нь тодорхой ашиг хүртэж, хуримтлал бий болгосон хэсэг нь мал аж ахуй эрхлэх, дэлгүүр, хоршоо ажиллуулах, газар тариалан эрхлэх болон жижиг, дунд бизнесийн **бусад** үйл ажиллагаанд шилжсэнтэй холбон үзэж болох юм.

Хэдийгээр хувиараа ашигт малтмал олборлогчдын талаарх мэдээллийг АМГ орон нутгаас авч нэгтгэж байгаа боловч иргэд тэр бүр орон нутгийн бүртгэлд хамрагддаггүй, мэдээлэл бодитой бус, зарим аймаг мэдээгээ өгдөггүй зэргээс шалтгаалан бүрэн дүүрэн шинжтэй байж чаддаггүй тал бий. Түүнээс гадна хэдэн нэр төрлийн ашигт малтмалыг хаана, хэдэн хүн ямар техник, технологи ашиглан олборлож, хэрхэн борлуулалт хийж байгаа талаарх тодорхой мэдээлэл, судалгаа байдаггүй, тэдний эрхэлж байгаа үйл ажиллагааны онцлог болох ашигт малтмалын нөөц, олборлолтын нөхцөл, түүнийг дагасан шилжилт хөдөлгөөний урсгалтай дээрх асуудал шууд холбоотой байж болох юм.

4.1.Алт олборлолт:

Монгол Улсын Засгийн газар алт олборлох үйл ажиллагаанд гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татах зорилгоор 1992 онд “Алт” хөтөлбөрийг анх батлан гаргаж, улмаар 1994 онд “Ашигт малтмалын тухай хууль” гарсан, 2000 оноос “Алт -2” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн нь уул уурхайн салбарын үсрэнгүй хөгжлийн үндэс суурь болжээ. Ингэснээр өнгөрсөн 17 жилийн дотор Монгол улсын алтны үйлдвэрлэл асар хурдацтай хөгжсөн бөгөөд бараг 30 дахин нэмэгдсэн байна. Гэхдээ Улсын Их Хурлаас 2006 онд ашигт малтмалын тухай хуульд оруулсан томоохон өөрчлөлтүүд, алт, зэсийн үнийн гэнэтийн өсөлтийн татварын тухай хууль батлагдсан зэрэг нь нийт уул уурхайн салбар, ялангуяа алт үйлдвэрлэлийн салбарт сөргөөр нөлөөлсөн. Үүний улмаас 2005 онд Монгол улс 24.1 тонн алт олборлодог байсан бол 2008 онд 38,5 хувиар буюу 15,1 тонн болтлоо буурчээ.

Алт олборлолт Монгол улсын хэмжээнд:

Ашигт малтмалын нэр төрөл	2006 он	2007 он	2008 он	2009 он
Алт (кг)	22561,3	17472,5	15183,8	9803,3

Хэдийгээр манай орны алт олборлолт буурсан харагдаж байгаа боловч тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн олборлолт, үйлдвэрлэлийн хэмжээ огтхон ч буураагүй болохыг бие даасан судлаачид хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр мэдээлсэн байдаг. Аж ахуйн нэгжүүд олборлосон алтаа Монгол банкинд тушаах, экспортонд гаргах хэмжээг эрс бууруулан хар захад гаргасан байж болох үндэслэлүүд байгаа болохыг тэдгээр судлаачид нотлохыг оролдсон байдаг.


Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтны экспорт

	2006 он	2007 он	2008 он	2009 он
Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт (тн)	15,4	11,6	22,1	10,9

Бичил уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг хувиараа ашигт малтмал олборлогчдын дийлэнх хэсэг нь алтны үндсэн болон шороон ордод олборлолт явуулдаг. Хувиараа ашигт малтмал олборлогчдын дийлэнх олонх нь үндсэн болон шороон ордоос алт олборлож байгаа нь нэг талаас сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээл дээрх алтны үнэ ханш өндөр байгаа төдийгүй тасралтгүй өсч **буйтай**, нөгөө талаас олборлосон бүтээгдэхүүн болох алтны маш хурдан хөрвөх чадвартай холбоотой юм.



Хувиараа ашигт малтмал олборлогчдын тоо



Байршил:

Архангай, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Өмнөговь, Дорнод, Говь-Алтай, Төв, Сэлэнгэ, Хэнтий, Увс, Ховд, Дархан-Уул, Хөвсгөл аймаг зэрэг нийт 14 аймагт шороон болон үндсэн ордоос алт олборлох үйл ажиллагаа явагдаж байна.

Тухайлбал, АМГ-аас гаргасан бичил уурхайд олборлож байгаа ашигт малтмалын нэр төрөл, олборлогчдын тоо, бүртгэлээс үзэхэд 2006 онд 65645, 2007 онд 59292, 2008 онд 48905, 2009 онд 29790, 2010 онд 54780 хувиараа ашигт малтмал олборлогч алт олборлох чиглэлээр ажиллаж байжээ. Ашигт малтмал олборлогчдын тоо жилээс жилд буурсан харагдаж байгаа боловч бодит амьдрал дээр буураагүй, харин ч өссөн байх магадлал өндөр юм.


Хувиараа ашигт малтмал олборлогч 1 иргэн өдөрт дундажаар **0,5** гр алт олборлодог гэж олон улсын байгууллагын болон бие даасан судлаачид тодорхойлсон байдаг. ТоБУТ-өөс захиалан хийлгэсэн хувиараа ашигт малтмал олборлогчдын нийгэм, эдийн засгийн суурь судалгаагаар гарсан үр дүнг үзвэл дараах байдалтай байна.

Хувиараа ашигт малтмал олборлогч нэг иргэний олборлож буй алтны дундаж хэмжээ

№	Үзүүлэлтүүд	Уянга сум	Бигэр сум	Борнуур сум	Жаргалант сум	Дундаж
1	Орлоготой ажилладаг өдөр (сард)	23	21	15	21	20
2	Олборлож буй алтны дундаж хэмжээ (гр)	0,3	0,2	0,6	0,5	0,4

Судалгаанд хамрагдсан дээрх 4 сумаас Борнуур сумын хувиараа ашигт малтмал олборлогчид нь алтны үндсэн ордоос, бусад нь шороон ордоос алт олборлох үйл ажиллагаа явуулдаг онцлогтой.

Суурь судалгааны үндсэн дээр гарч ирсэн үр дүн нь олон улсын байгууллага, бие даасан судлаачдын тодорхойлсон үзүүлэлтээс 0,1 гр-аар бага байгаа нь сонирхол татаж болох юм. Мөн олон жил ашиглагдсан ордын хүдрийн агууламж буурч байгаа болохыг үгүйсгэх аргагүй. Гэхдээ өмнө тодорхойлогдсон дундаж үзүүлэлтийг 2005-2006 оны үед олон улсын байгууллага, бие даасан судлаачид тогтоосон болохыг харгалзан үзэх шаардлагатай.



Хувиараа ашигт малтмал олборлогч нэг иргэний өдөрт олборлож байгаа алтны дундаж хэмжээг орон нутагт явуулсан суурь судалгааны үр дүнг баримтлан 0,4 гр гэж үзээд, сард 20 өдөр ажилладаг гэсэн үзүүлэлтээр жишиглэн нийт хувиараа алт олборлогчдын олборлосон алтны хэмжээг тооцож үзэхэд 2006 онд 6301,9 кг, 2007 онд 5692,03 кг, 2008 онд 4694,9 кг, 2009 онд 2859,8 кг алтыг тус тус олборлож, 4 жилийн дундажийг авч үзвээс дундажаар 4887,2 кг алт олборлосон гэсэн дүгнэлт гарч байна. Алт олборлох үйл ажиллагаанд хамгийн энгийн хөдөлмөрийн багаж хэрэгслээс орчин үеийн техник хэрэгслийг хүртэл ашигладаг байна.

Хувиараа ашигт малтмал олборлогчдын 2009 онд олборлосон алтны хэмжээ нь Монгол улсын хэмжээнд тухайн онд олборлосон нийт алтны **29,2** хувьтай тэнцэж байна. Өөрөөр хэлбэл, Монгол улсын боловсруулаагүй алтны үйлдвэрлэлийн **22,6** хувийг хувиараа ашигт малтмал олборлогчид үйлдвэрлэж байна гэсэн үг юм.

4.2.Алтны борлуулалтын зах зээл.

Алтны борлуулалт ямар нэг зохицуулалтгүй хийгдсээр байна. Орон нутгийн хувиараа ашигт малтмал олборлогчид өөрсдийн олборлосон алтаа явуулын болон нутгийн ченжүүдэд газар дээр нь зарж борлуулдаг бөгөөд худалдан авагчид нь хууль бус алтны зах зээлд цааш дамжуулан борлуулдаг байна. Албан бус худалдан авагч буюу ченжүүд нь ямар ч баталгаагүй жин хэмжүүр ашигладаг учир алт борлуулж байгаа хувиараа ашигт малтмал олборлогчид үүнд нь сэтгэл дундуур үлддэг ч аль аль нь хууль бус үйл ажиллагаа тул асуудал үүсгээд байдаггүй ажээ.

Иргэдээс Монгол банкинд тушаасан алтны хэмжээ

	Ашигт малтмалын нэр төрөл	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он
1	Алт (кг)	1715	515	236	564	

Иргэдээс Монгол банк худалдан авсан алтны хэмжээг үндсэн үзүүлэлт болгон авч үзвэл хувиараа ашигт малтмал олборлогчид 2006 онд олборлосон алтныхаа 8,2 хувийг, 2007 онд 4,1 хувийг, 2008 онд 12,01 хувийг тус тус албан зах зээлд борлуулжээ. Харин үлдсэн хувийг алтны хууль бус зах зээлд борлуулсан байна гэж үзэхээс өөр аргагүй.

Албан ёсны зах зээлд алт борлуулахад тавигдах шаардлагын нэг нь сорьцын баталгаа хийлгэсэн байх явдал юм. Сорьцын хяналтын улсын албаны Үнэт металлын сорьц тогтоох лаборатори нь Улаанбаатар хотод байрладаг бөгөөд Монгол Улсын хэмжээнд үнэт металл, тэдгээрийн хайлш, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, гулдмай, үнэт металлаар хийсэн эдлэлд химийн шинжилгээ хийж, сорьц тогтоон, сорьцын баталгааны тэмдэг дардаг монополь эрхтэй ганц байгууллага. Гэтэл хувиараа алт олборлох үйл ажиллагаа ихэвчлэн хот суурин газраас алслагдмал бөглүү газарт явагддаг тул энэ лабораторийг зорьж ирэх замын зардал, үйлчилгээний хөлс нь хувиараа ашигт малтмал олборлогчдод хүндрэл учруулдаг болох нь энгийн хүнд ч ойлгомжтой. Монгол банкнаас гадна арилжааны банкуудын орон нутгийн салбаруудад алт тушааж болох хэдий ч арилжааны банкууд алт экспортлох эрхгүй тул төдийлөн алт худалдаж авах сонирхолгүй байдаг.

Ийнхүү хувиараа ашигт малтмал олборлогчдын борлуулсан алт нь эх орныхоо эрдэнэсийн санд бус хууль бусаар алт хил давуулан худалддаг бүлэг хүмүүсийн гарт ордог нь тодорхой юм. Хууль бусаар хил давуулж байгаа гэх үндэслэлийг хэвлэл мэдээлийн хэрэгсэлээр цацагдсан 2007.07.03 ны өдөр Замын –Үүдийн хилийн боомтоор 2,1 кг, мөн оны 10 дугаар сард 14,089 кг, 2008 оны 8 дугаар сард 10,6 кг цэвэр алт хил давуулах оролдлогуудыг гаалийн шалгалтаар илрүүлсэн зэрэг олон зөрчлүүд бодит баримтаар харуулж байна.

Хувиараа ашигт малтмал олборлогчдын борлуулалтын орлогыг тооцохдоо тухайн жилийн дэлхийн зах зээлийн дундаж үнийг авч үзэхээс өөр аргагүй байгаа нь алтны үнэ ханшны хэлбэлзэл их байсантай холбоотой болно.

Дэлхийн зах зээлийн буюу Лондоны металлын бирж дээрх ашигт малтмалын үнэ ханш


Алт	2008 оны 12 дугаар сарын дундажаар	2009 оны 6 дугаар сарын дундажаар
1 унци (ам доллараар)	816	915

Дээр дурдсан үнэ ханшаар борлуулалт хийсэн гэж үзвэл 2008 онд хувиараа ашигт малтмал олборлогчид 4694,9 кг алтны борлуулалтаас 123,2 сая ам доллар, 2009 онд 2859,8 кг алтны борлуулалтаас 84,1 сая ам долларын орлого олжээ. Энэхүү тооцооллоор жишиглэн 2009 оны байдлаар хувиараа ашигт малтмал олборлогч нэг хүн 2824,07 ам долларын борлуулалтын орлого олсон гэж үзэж болох юм.

Алт борлуулах албан бус зах зээлийн үйл ажиллагааны цаана хувь хүн хөдөлмөрөө дутуу үнэлүүлэх, орлогын албан татвар тооцогдохгүй үлдэх, алт олборлох үйлдвэрлэл эдийн засагт

тооцогдохгүй хоцрох, ашигт малтмалын нөөц хууль бусаар ашиглагдах зэрэг микро болон макро түвшний олон сөрөг үр дагавар оршиж байдаг тул хувиараа ашигт малтмал олборлогчдын хууль эрх зүйн орчныг сайжруулах бодлогын хүрээнд ашигт малтмалын борлуулалтын асуудлыг хамтад нь анхаарч, зохих арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай юм.

4.3. Жонш олборлолт.



Байршил:

Дорноговь аймгийн Даланжаргалан, Айраг, Өргөн, Дундговь аймгийн Цагаандэлгэр, Хэнтий аймгийн Бор-Өндөр, Бэрх тосгон

Жонш олборлодог хувиараа ашигт малтмал олборлогчид:

- өмнө нь аж ахуйн нэгжүүд хайлуур жонш олборлоод нөхөн сэргээлт хийлгүй орхисон талбайд,
- аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрөлтэй газруудаас хулгайгаар,
- жонш гарч болох магадлалтай эрүүл газарт,
- орон нутгийн засаг захиргаатай гэрээ байгуулан олборлолт явуулах зөвшөөрөлтэй газруудад тус тус жонш олборлох үйл ажиллагаа явуулдаг.

2009 оны байдлаар жонш олборлох үйл ажиллагаанд 1856 хувиараа ашигт малтмал олборлогч иргэд оролцож байна гэсэн АМГ-ын мэдээлэл байна.

Жонш олборлох үйл ажиллагаанд хүрз, лоом, жоотуу, алх зэрэг хамгийн энгийн багаж хэрэгслүүдээс өргөгч кран, компрессор зэрэг бүтээмж өндөртэй техник хүртэл ашигладаг хэдий ч хувиараа ашигт малтмал олборлогч 1 иргэн өдөрт 0,5 тн жонш олборлодог тухай мэдээллийг жонш олборлогчид хамгийн олноор бөөгнөрөн үйл ажиллагаа явуулдаг Дорноговь аймгийн Айраг сумын засаг захиргаанаас өгсөн бөгөөд энэхүү мэдээллийг бусад орон нутгийн хувиараа ашигт малтмал олборлогчидтой уулзах үед оролцооны аргаар хийсэн судалгааны явцад баталгаажуулсан.

Жонш үйлдвэрлэлийн хэмжээг дээрх мэдээлэлд үндэслэн тооцоолж үзвэл:

- 2006 онд 236,7 мянган тн,
- 2007 онд 216,1 мянган тн,
- 2008 онд 136,2 мянган тн,
- 2009 онд 111,4 мянган тн,
- 2010 онд 138,0 мянган тн жонш тус тус олборложээ.
-

Хайлуур жонш үйлдвэрлэлийн хэмжээ.


	Ашигт малтмалын нэр төрөл	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он
1	Хайлуур жонш (мянган тн)	521,4	521,9	637,9	545,8	628,8

2009 оны байдлаар улсын хэмжээнд үйлдвэрлэсэн хайлуур жоншны **17,7** хувьтай тэнцэх хэмжээний жоншийг хувиараа ашигт малтмал олборлогчид олборложээ. Түүнчлэн Монгол улсын хэмжээнд үйлдвэрлэж байгаа хайлуур жоншны үйлдвэрлэлийн **15,04** хувийг хувиараа ашигт малтмал олборлогчид үйлдвэрлэж байна гэж үзэх боломжтой байна.

Хувиараа ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааны үр дагаварууд	
Эерэг үр дагавар:	Сөрөг үр дагавар:
- Хувиараа жонш олборлогчид өөртөө ажлын байрыг бий болгон ажилгүйдлийг бууруулсан. - Хувиараа жонш олборлогчид өөрсдийн гэр бүлийг орлогын эх үүсвэрээр хангаж байна. - Орон нутгийн үйлдвэрлэл үйлчилгээний борлуулалтын орлогыг нэмэгдүүлдэг. - Ашигт малтмалын нөөцийг хаягдалгүй бүрэн ашигладаг. - Олборлолтоос олсон орлогыг хүүхдээ сургуульд сургах, хуримтлал бий болгох, хөрөнгө худалдаж авах зэргээр ашиглан амьжиргааны түвшингээ дээшлүүлж байна.	- Орон нутгийн төсөвт татвар төлдөггүй - Малын бэлчээрийн хомсдол үүсгэж байна. - Зохион байгуулалт, бүртгэлгүй. - Хууль, дэг журмыг үл хүндэтгэх - Өөр аймаг, сумын иргэд ирж ажиллан гэмт хэрэг, осол аваарын хэмжээг нэмэгдүүлэх. - Технологийн дагуу үйлдвэрлэл явуулж байгаа уурхайнуудад чирэгдэл учруулах. - Олборлолт явуулаад нөхөн сэргээлт хийлгүй орхисон нүх, цооногт хүн, мал, амьтан унаж бэртэж гэмтэх.

4.4.Жонш борлуулалт:

Хувиараа ашигт малтмал олборлогчдын борлуулалтын суваг нь дараах байдалтай байна.




Жонш олборлогчдын бүтээгдэхүүний үндсэн хэрэглэгчид нь гадаад зах зээл дээр байгаа үйлдвэрлэгчид байдаг. Жонш олборлох тусгай зөвшөөрөлтэй зарим жижиг, дунд аж ахуйн нэгжүүд олборлолтын зардал өндөр байдгаас шалтгаалан орон нутгийн хувиараа ашигт малтмал олборлогчдын олборлосон жоншийг худалдан авч гадаад зах зээл дээр борлуулах үйл ажиллагааг явуулахаас гадна томоохон олборлогч аж ахуйн нэгжүүдэд нийлүүлдэг байна. Тэдгээрээс гадна завсарын худалдаачид хувиараа ашигт малтмал олборлогчдын эргэлтийн хөрөнгийн хомсдолыг нь ашиглан хямд үнээр худалдан авч, цааш дамжуулан борлуулах замаар ашиг олдог. Орон нутагт агууламжаас шалтгаалан 1тн жоншны үнэ 35,0-145,0 мянган төгрөгийн үнээр тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүд болон завсарын худалдаачид худалдаж авдаг ажээ. Жонш олборлолт, борлуулалттай холбоотойгоор тулгамдаж байгаа асуудлууд:

- Олборлолт явуулах газар, зөвшөөрөл
- Хууль бус, хулгайгаар хийж байгаа тэсэлгээ
- Хувиараа ашигт малтмал олборлогчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа


- Борлуулалтын оновчтой сувгийг бий болгох
- Уул уурхайн томоохон аж ахуйн нэгжүүд ба хувиараа ашигт малтмал олборлогчдын харилцан ойлголцлыг бий болгох
- Хувиараа ашигт малтмал олборлогчидтой хамтран ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх

4.5.Нүүрс олборлолт

Шилжилтийн эхний жилүүдэд 5000 гаруй ажиллагсадтай байсан Налайхын их уурхай хаагдахад тус уурхайд үе дамжин ажиллаж ирсэн уурхайчид ажилгүйчүүдийн эгнээнд шилжсэн билээ. Ийнхүү ажил, амь зуулгаасаа салсан уурхайчид амьдрахын эрхээр хууль бусаар нүүрс олборлож эхэлснээр анхны хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа эхэлсэн түүхтэй.



Хувиараа нүүрс олборлох үйл ажиллагаа Улаанбаатар хотын Налайх дүүрэгт төвлөрөн явагдаж байгаа бөгөөд 2009 оны байдлаар 914 хүн ажиллаж байгаа гэсэн албан ёсны мэдээлэл байдаг. Тэдгээр хувиараа ашигт малтмал олборлогчид нүүрс олборлохдоо бригадын зохион байгуулалтаар ажилладаг. Хувиараа ашигт малтмал олборлогчид уурхайн ам эзэмшиж байгаа хувь хүмүүст түрээс төлөх байдлаар олборлолт явуулдаг ба 5-10 хүн нэг бригад болдог байна. Мөн уурхайн ам эзэмшиж байгаа хувь хүн хувиараа ашигт малтмал олборлогчдын бригадыг цалинжуулан ажиллуулах нь элбэг. Алт олборлогчдыг бодвол харьцангуй тогтвортойн зэрэгцээ их уурхайд ажиллаж байсан туршлагатай хүмүүс бригадын гол удирдлагыг атгаж олборлолт явуулдаг тул мэргэжлийн түвшний ажиллагаатай гэж хэлж болох юм.



Хувиараа ашигт малтмал олборлогчдын олборлож буй нүүрс олборлолтын хэмжээ 2006 онд Монгол улсын нийт нүүрс олборлолтын 4,3 хувийг, 2007 онд 4,4 хувийг, 2008 онд 3,7 хувийг, 2009 онд 2,6 хувийг тус тус эзэлж байв.

Налайх дүүргийн хувиараа нүүрс олборлогч иргэдийн олборлолтын хэмжээ

Ашигт малтмалын нэр төрөл	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он
нүүрс (мянган тн)	512,1	344,0	410,9	374,2	370,1

Тавдугаар бүлэг. Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшин

5.1.Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн орлого



Монгол Улсын 2009 оны статистикийн эмхтгэлд дурдсанаар өрхийн сарын дундаж мөнгөн орлого 2009 онд 355,0 мян төг болж 2008 оныхтой харьцуулахад 9,1 хувь, үүнээс цалингийнх 13,9 хувь, тэтгэвэр, тэтгэмжийнх 10,1 хувь, бусад орлого 14,7 хувиар тус тус нэмэгдсэн байна. Ажиллагчдын сарын дундаж цалин 2009 онд 300,5 мян төг болж 2006 оныхоос 2,4 дахин, 2007 оныхоос 1,7 дахин, 2008 оныхоос 9,6 хувиар өсчээ.

Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн сарын дундаж орлогыг тодорхойлохын тулд Баянхонгор аймгийн Жаргалант, Төв аймгийн Борнуур, Говь-Алтай аймгийн Бигэр, Өвөрхангай аймгийн Уянга зэрэг сумдад явуулсан нийгэм эдийн засгийн суурь судалгааг үндэс болгон авч үзлээ. Үндсэн ба шороон ордоос алт олборлох үйл ажиллагаанаас хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн 1 сард олдог орлогын хэмжээ нийгэм эдийн засгийн суурь судалгаагаар дараах байдалтай байна.

Хувиараа ашигт малтмал олборлогч иргэний сарын орлого

	Хувиараа ашигт малтмал олборлогч иргэний 1 сарын орлогын хэмжээ
Төв аймаг. Борнуур сум.	360.000
Баянхонгор аймаг. Жаргалант сум.	231000
Өвөрхангай аймаг. Уянга сум	310.000
Говь-Алтай аймаг. Бигэр сум	246.500
Дундаж орлогын хэмжээ	286,875

Төв аймгийн Борнуур суманд амьдардаг хувиараа ашигт малтмал олборлогч нэг иргэний сарын дундаж орлого бусад орон нутгийн хувиараа ашигт малтмал олборлогчдынхоос 50000-113500 төгрөгөөр илүү байгаа нь алтны үндсэн ордод ажилладаг, төвлөрсөн зах зээлд ойрхон зэргээс нь хамааралтай бөгөөд олборлосон алтаа өндөр үнээр борлуулах боломж нөхцөлөөр илүү, нэг сард олборлох алтны дундаж хэмжээ ахиу байгаа зэрэгтэй шууд холбоотой хэмээн дүгнэж болох юм. Харин ийм дүгнэлт хийхдээ хувиараа ашигт малтмал олборлогчид өөрсдийнхөө

орлогын хэмжээг үнэн бодитоор нь мэдээлэх сонирхол багатай байдгийг судлаачид анхаарах хэрэгтэй.

Хувиараа ашигт малтмал олборлогчдын 1 сарын дундаж орлогын хэмжээ харилцан адилгүй байгаа нь тэдгээрийн байршил, олборлолт ба баяжуулах технологи, зах зээлээс алслагдсан байдал, олборлолт явуулж буй ордын хэлбэр, агуулга, олборлосон алтны борлуулалтын ханш зэрэг хүчин зүйлүүдтэй мөн холбоотой.

Хэдийгээр дээрх хүчин зүйлүүдийн улмаас хувиараа ашигт малтмал олборлогчдын сарын орлогын хэмжээ газар бүр өөр буюу хооронд нь харьцуулахад тодорхой хэлбэлзэлтэй байгаа боловч **дээрх** судалгааны үр дүнгээс үзэхэд дундажаар **286,875** төгрөг байна гэж үзэх боломжтой юм.

Аж ахуйн нэгж, төрийн байгууллагын ажиллагсдын сарын дундаж цалин (мянган төгрөг)

Салбарын нэр	2006 он	2007 он	2008 он	2009 он
Уул уурхай олборлох аж үйлдвэр	146,1	219,7	328,6	405,8
Төрийн удирдлага	141,3	194,0	327,3	332,0
Боловсрол	123,6	174,3	289,2	297,3
Эрүүл мэнд, нийгмийн халамж	116,5	166,0	295,8	298,4

Хувиараа ашигт малтмал олборлогч иргэний сарын дундаж орлогыг аж ахуйн нэгж байгууллагын ажиллагсдын сарын дундаж цалинтай харьцуулахад:

- Уул уурхайн олборлох аж үйлдвэрийн ажиллагсдын сарын дундаж цалингаас **41,5** хувиар
- Төрийн удирдлагад ажиллагсдын сарын дундаж цалингаас **15,7** хувиар
- Боловсролын салбарт ажиллагсдын сарын дундаж цалингаас **3,6** хувиар
- Эрүүл мэнд, нийгмийн халамжийн ажиллагсдын сарын дундаж цалингаас **4,01** хувиар тус тус доогуур байна гэсэн дүгнэлт гарч байна.

Орон нутгийн төсвийн болон бусад аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа ажилчдын сарын дундаж орлогыг хувиараа ашигт малтмал олборлогч иргэний сарын дундаж орлоготой харьцуулж авч үзвэл:

- Судалгааны мэдээллээр Борнуур суманд төсвийн болон бусад аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж байгаа ажилчдын сарын дундаж цалин 237,000 төгрөг байна.
- Харин хувиараа ашигт малтмал олборлогч иргэний сарын дундаж орлого төсвийн болон бусад аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа ажилчдын сарын дундаж орлогоос **17,4** хувиар илүү байна.

Эндээс дүгнэхэд хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа нь орлого олох боломжтой, ажил олгогчийн зүгээс дарамт шахалт бага, мэргэжил мэдлэг шаарддаггүй, харьцангуй эрх чөлөөтэй, гэр бүлээрээ хийх боломжтой ажил учир иргэдийн дунд алт олборлох сонирхол түлхүү байгаа мэт харагдаж болох юм.

Гэхдээ хувиараа ашигт малтмал олборлогч нэг иргэний хувьд бол түүний сарын дундаж орлого боломжийн мэт харагдаж байгаа боловч хувиараа ашигт малтмал олборлогчдын ам бүлийн дундаж тоо **4,6** байгаа гэсэн судалгааны үр дүнтэй зэрэгцүүлэн авч үзвэл өрхийн нэг гишүүнд ногдох орлого маш бага байх магадлалтай.

5.2. Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн зарлага.

Хувиараа ашигт малтмал олборлогчид алт олборлох үйл ажиллагаа явуулахдаа үйлдвэрлэлийн багаж хэрэгсэл худалдан авах, тоног төхөөрөмж түрээслэх, тээвэрлэх, алтны шороо угаах, хоол хүнс худалдан авах зэрэгт багагүй зардал гаргадаг болох нь судалгаагаар тогтоогдсон. Энэхүү зардлын дундажийг судалгаанд хамрагдсан орон нутгаар гаргаж үзүүлбээс:

Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааны зардал(төгрөгөөр)

Үзүүлэлт	Бигэр сум	Борнуур сум	Жаргалант сум.	Уянга сум	Дундаж
Сарын нийт зардлын дундаж хэмжээ	62 597	100 000	105 000	90 000	89399

Хувиараа ашигт малтмал олборлогч иргэн алт олборлох үйлдвэрлэлтэй холбоотойгоор дундажаар **89399** төгрөгийн зардал гаргадаг болох нь судалгааны үр дүнд тогтоогдож байна. Гэхдээ энэ зардал нь өвлийн улиралд эрс нэмэгдэж, дулааны улиралд буурах зэрэг хэлбэлзэлтэй байх болно.

Мөн ашигт малтмалын ордын нөөц, түүний олборлолтын онцлог, байгаль, цаг уурын нөхцөл болон тухайн хувиараа ашигт малтмал олборлогчийн хөдөлмөрийн бүтээмж, ур чадвар, туршлага зэргээс олборлолтын зардлын өсөлт шууд хамааралтай байх учир хувиараа ашигт малтмал олборлогч нэг иргэний сарын нийт зардлын дундаж хэмжээг нарийвчлан тогтооход хүндрэлтэй байна.

5.3. Хувиараа ашигт малтмал олборлогчдын амьжиргааны түвшин.

Монгол Улсын 2009 оны статистикийн эмхтгэлд дурдсанаас үзвэл өрхийн нийгэм эдийн засгийн түүвэр судалгаагаар нэг өрхийн сарын дундаж нийт орлого тухайн оны үнээр 2009 онд 402,5 мян төгрөг болж, 2008 онтой харьцуулбал 10.7 хувь өссөн байна.

Өрхийн нэг хүнд ногдох сарын орлогын мэдээлэл нь тухайн өрхийн амьжиргааны түвшнийг ерөнхийлөн хэмжих гол үзүүлэлт байдаг ба өрхүүдийг амьжиргааны түвшингээр нь ядуу болон ядуу бус гэж ангилж болдог.

Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн өрхийн амьжиргааны түвшинг Говь-Алтай аймгийн Бигэр сумын хувиараа алт олборлогч иргэдийн өрхийн амьжиргааны түвшингээр төлөөлүүлэн харуулбал:

Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн өрхийн амьжиргааны түвшин

	Өрхийн амьжиргааны үзүүлэлтүүд	Хувиараа ашигт малтмал олборлогчдын эзэлж буй хувь
1	1 өрхөд буй орлого олохуйц ажил эрхэлдэг хүний тоо	
	1 хүн	61,3
	2 хүн	35,4
	3 хүн	3,3
	Нэг өрхөд буй ажил эрхэлдэг хүний дундаж тоо	1,42
2	Өрхийн сарын нийт орлого (төгрөгөөр)	
	262 850-аас доош	25,0
	262 850-358 499 хүртэл	25,0
	358 499 -482 999 хүртэл	24,7
	483 000-аас дээш	24,3
3	Нэг өрхийн дундаж орлого (төгрөгөөр)	396 262
	Өрхийн нэг хүнд ногдох дундаж орлого (төгрөгөөр)	103 256
	Өрхийн нэг хүнд ногдох сарын голч (медиан)орлого (төгрөгөөр)	86 733,3
4	Өрхийн амьжиргааны түвшин (хувиар)	
	Ядуу бус өрх	40,0
	Ядуу өрх	60,0
	Үүнээс: Нэн ядуу	23,0
	Бүх өрх дэх нийт хүн амд ядуу хүн амын эзлэх хувь	68,0
Тайлбар		

Ядуу өрх:

Өрхийн нэг хүнд ногдох сарын орлого нь 2009 оны Баруун бүсийн 1 хүнд сард ногдох амьжиргааны доод түвшингийн үзүүлэлт (ядуурлын шугам) болох 96100 төгрөгөөс доош орлоготой байгаа өрх.

Нэн ядуу өрх:

Өрхийн нэг хүнд оногдох сарын орлого нь ядуурлын шугамын 60 хувьд хүрэхгүй байгаа өрх

Эх сурвалж: “Говь-Алтай аймгийн Бигэр сумын нийгэм эдийн засгийн суурь судалгаа 2010 он”.
Хөгжлийн эзэд ТББ

Дээрх хүснэгтээс үзэхэд судалгаанд хамрагдсан хувиараа алт олборлогч иргэдийн нийт өрхийн 40,0 хувь нь ядуу бус, 60,0 хувийг нь ядуу өрх эзэлж байна. Ядуу өрхүүдийн 23,0 хувийг нэн ядуу буюу өрхийн нэг хүнд оногдох сарын орлого нь ядуурлын шугамын 60 хувьд хүрэхгүй байгаа өрх эзэлж байгаа ажээ. Мөн судалгаанд хамрагдсан нийт өрх дэх хүн амын 68 хувийг ядуу хүн ам эзэлж байгаа болохыг тогтоожээ. Эдгээр тоо баримтууд ядуурал бол хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд татагдан орох нэг үндсэн шалтгаан мөн болохыг нотлож байгаа үзүүлэлтүүд гэж үзэж болох юм.

Зургадугаар бүлэг. Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн эрүүл мэнд, нийгмийн даатгал, хүн амын орлогын татвар төлөлт

6.1. Эрүүл мэндийн байдал ба эрүүл мэндийн тусламж үйлчилгээ.



Монгол Улсын Үндсэн хуульд “иргэд хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй” гэж заасны дагуу хувиараа ашигт малтмал олборлогч иргэд ямар ч үед эрүүл мэндийнхээ төлөө санаа тавих, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй билээ.

Энэхүү харилцааг эрүүл мэндийн тухай, иргэний эрүүл мэндийн даатгалын тухай, эмийн тухай, ариун цэврийн тухай болон бусад хууль тогтоомжоор зохицуулж байна. Иргэд эрүүл мэндийн даатгалтай нөхцөлд холбогдох хууль журамд заагдсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээр үнэ төлбөргүй хангагдана.

Бид хувиараа ашигт малтмал олборлогчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдах байдлыг судалгааны үр дүнгээс авч үзэхэд дараах дүр зураг харагдаж байлаа. Судалгаанд хамрагдсан хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн дийлэнх нь алт олборлож эхэлснээс хойш цээжээр хатгуулан ханиалгах зовиур илэрдэг, үе мөч, бөөр өвдөх, шээс ойр ойрхон хүрэх, ууц нуруугаар өвдөх, хоолой сөөх зэрэг өвчлөл, зовиуртай байгаа нь тэд агааргүй, тоосжилттой, хүйтэн, чийгтэй орчинд хүнд хүчир ажил эрхэлж, хүнд жинтэй шороо, хүдэр өргөж зөөх, удаан хугацаагаар зогсох зэргээр ажиллаж байгаагаас үүдэлтэй болох нь мэргэжлийн хүмүүстэй хийсэн ярилцлагаар батлагдагдсан болно. Дээрх төрлийн өвчлөл нь 35-аас дээш насны эмэгтэйчүүд, 45-аас дээш насны

эрэгтэйчүүдийн дунд нийтлэг тохиолдож байгаа нь судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх явцад харагдаж байсан байна.

ХАМО иргэд эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал. (хувиар)

Үзүүлэлт	Бигэр сум	Борнуур сум	Жаргалант сум	Уянга сум
Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал	54,3	65,0	84,2	8,0
Дундаж	52,8			

Дээрх хүснэгтээс үзэхэд хувиараа ашигт малтмал олборлогчдын 52,8 орчим хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна. Гэхдээ үүнийг бодит үзүүлэлт гэж үзэхэд учир дутагдалтай. Хувиараа ашигт малтмал олборлогч иргэн зөвхөн эрүүл мэндийн даатгалтай байх нь хангалтгүй бөгөөд түүнийхээ шимтгэлийг тухай бүр бүрэн төлсөн тохиолдолд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй авах эрх нь баталгааждаг.

Хэдийгээр дээрх дундаж үзүүлэлтээр баримжаалан хувиараа ашигт малтмал олборлогчид өөрсдийн эрүүл мэндэд санаа тавьдаг гэж үзэх, тэд эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах, тусламж үйлчилгээ авах нөхцлүүд бүрдэж байна гэж үзэж болох боловч чухамдаа эмнэлгийн тусламж үйлчилгээ тэр бүр аваад байж чаддаггүй болох нь судалгааны явцад тогтоогджээ.

Тухайн үед мөрдөгдөж байсан түр журмын хүрээнд бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж байгаа Жаргалант, Борнуур зэрэг сумдын хувиараа ашигт малтмал олборлогчид эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал харьцангуй илүү байгаа нь харагдаж байна. Үүнийг ТоБУТ-ийн болон хувиараа ашигт малтмал олборлогчдын үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагуудын зүгээс явуулсан сургалт, сурталчилгаа зэрэг идэвхитэй үйл ажиллагааны үр дүн гэж үзэж болох юм.

Хувиараа ашигт малтмал олборлогчид хүндээр өвчлөх, эсвэл халдварт бус өвчин хөнгөн туссан тохиолдолд ажлаа хийж амьжиргаагаа залгуулахын тулд өвчин намдаах эм тан ууж **аргацаах** зэргээр өвчнөө архагшуулах явдал олонтоо тохиолддог ажээ. Нөгөө талаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад дараах хүндрэл бэрхшээлүүд гардаг байна:

- Эрүүл мэндийн тусламж авах газраас хол алслагдсан байх
- Орон нутгийн харьяалалгүй байх
- Тээврийн хэрэгсэл дутмаг байх
- Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй байх
- Холбоо харилцаа хангалтгүй байх

Харин хувиараа ашигт малтмал олборлогчид мөнгө төгрөгийн боломж муу, иргэний бичиг баримтгүй, яаж хамрагдахаа мэдэхгүй байх болон тэд өөрсдөө зав байхгүй, надад хэрэггүй гэх зэргээр үздэгтэй нь тэд эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй байгаа шалтгаан гол төлөв холбоотой байгаа нь тэдэнтэй ярилцаж судлах явцад өгсөн хариултуудаас нь харагдаж байжээ. Нөгөөтэйгүүр даатгалд хамрагдаагүй хувиараа ашигт малтмал олборлогчдын дийлэнх хэсгийг ахимаг насны, ядуу өрхийн, бичиг үсэгт тайлагдаагүй болон бусад орон нутгийн иргэд эзэлж байсан ажээ.

Хувиараа ашигт малтмал олборлолттой холбоотой нэг жишээ сонирхуулахад:

Судалгаанд хамрагдсан Өвөрхангай аймгийн Уянга суманд 2009 оны байдлаар бэлгийн замын халдварт өвчнөөр нийт 169 хүн өвчилснөөс 80 хүн заг хүйтэн, 10 хүн тэмбүү, 76 хүн трихомоназ, 3 хүн мөөгөнцрөөр өвдөж эмчлүүлсэн тохиолдлууд бүртгэгджээ. Эдгээр тохиолдлуудын 60 хувь нь 20-35 насны эмэгтэйчүүдийн жирэмсний үеийн эмчийн хяналтын үед оношлогдож эмчлэгдсэн ажээ. Олон жил хууль бусаар алт олборлох үйл ажиллагаа явагдсан тус сумын судалгаанд оролцогч иргэдийн 21,0 хувь нь огт гэрлээгүй 23,5 хувь нь салсан, тусгаарласан, бэлэвсэн гэсэн үзүүлэлтэд багтаж байгаа нь анхаарал татаж байна.

Эндээс үзэхэд хувиараа ашигт малтмал олборлогчид бэлгийн замын өвчлөлийн оношлогоо, шинжилгээнд сайн дураараа хамрагддаггүй л болохоос, ер нь тэдний дунд бэлгийн замын халдварт өвчний тархалт их байх магадлал өндөр байгааг харуулж байгаа болно.

Эцэст нь хэлэхэд хувиараа ашигт малтмал олборлогчдын хүрээнд Монгол Улсын иргэн бүр эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулах шаардлагатай гэсэн “Эрүүл мэндийн даатгалын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн хэрэгжилт хангалтгүй байна гэж үзэж болохоор байна. Үүнээс үндэслэн хувиараа ашигт малтмал олборлогчид өөрийн болон өрхийн гишүүдийнхээ эрүүл мэндийн төлөө тавих анхаарал, хариуцлага, мэдлэг ойлголт нэн хангалтгүй байна гэсэн дүгнэлт хийж болох юм.

6.2. Нийгмийн даатгал, нийгмийн халамж

Монгол Улсын хэмжээнд 2009 онд нийгмийн даатгалд нийт 609.0 мянган хүн хамрагдсаны 557.3 мянга буюу 91,5 хувь нь заавал даатгуулагчид, 51.7 мянга буюу 8,5 хувь нь сайн дурын даатгуулагчид байна. Нийт даатгуулагчдын тоо өмнөх оныхоос 9,6 мянган хүнээр буюу 1,6 хувиар нэмэгдсэний дотор заавал даатгуулагчид 7,3 мянган хүнээр буюу 1,3 хувиар, сайн дурын даатгуулагчид 2,3 мянган хүнээр буюу 4,7 хувиар тус тус өссөн байна.

Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд оролцогчдын дотор нийгмийн даатгалд хамрагдагсдын хувь хэмжээ ямар байгааг орон нутагт явуулсан нийгэм, эдийн засгийн судалгааны үр дүнгээс харахад дараах байдалтай байна.

Үзүүлэлт	Бигэр сум	Борнуур сум	Жаргалант сум	Уянга сум	Дундаж
Нийгмийн даатгалд хамрагдсан байдал (хувиар)	1,0	26,0	37,4	0	16,1

Энэхүү хүснэгтээс үзэхэд хувиараа ашигт малтмал олборлогч нийт иргэдийн дунд сайн дурын даатгалд хамрагдаж, нийгмийн даатгалын шимтгэл төлдөг хүмүүсийн дундаж **16,1** хувь байгаа нь маш хангалтгүй үзүүлэлт юм.

Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагсан хувиараа ашигт малтмал олборлогчдыг нас хүйсээр нь авч үзвэл, 40-өөс дээш насны бүрэн дунд болон түүнээс дээш түвшний боловсролтой, орон нутгийн харьяалалтай, алт олборлолтоос жилд олдог ашгийн хэмжээ нь өндөр гэж үзэхүйц хүмүүс байдаг ба тэд сард дундажаар 16,0 мянга ба түүнээс дээш төгрөгийн шимтгэл төлдөг ажээ.

Сумаар нь авч үзвэл, Борнуур, Жаргалант сумын хувиараа ашигт малтмал олборлогчид нийгмийн даатгалд хамгийн илүү хамрагдаж байгаа нь харагдаж байна. Энэ үзүүлэлт нь тэдгээр хувиараа ашигт малтмал олборлогчид нэг талаас бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж, өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагаа байгуулж, гишүүнээр нь элсэн нийгмийн хариуцлагатай гишүүд болон төлөвшиж эхэлсэн, нөгөө талаар сум орон нутгийн удирдлага, нийгмийн даатгалын байгууллагын орон нутгийн ажилтнуудын сургалт, сурталчилгаа зэрэг идэвхи санаачлагатай үйл ажиллагаатай холбоотой. Мөн ТоБУТ-өөс хувиараа ашигт малтмал олборлогчдын дунд нийгмийн хариуцлагатай гишүүдийг төлөвшүүлэх, нийгмийн хариуцлагын тухай явуулж ирсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээний үр дүн гэж үзэхээр байна.

Нийгмийн даатгалд сайн дураар хамрагдахгүй байгаа шалтгааныг судалгааны явцад тодруулсан. Хамрагдахгүй байгаа шалтгаануудыг судалгаанд оролцогчид дараах байдлаар илэрхийлжээ. Үүнд:

- Мөнгө төгрөгний боломжгүй
- Нийгмийн даатгалд хамрагдах ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг мэдэхгүй
- Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах аргаа мэдэхгүй
- Зав байхгүй
- Нийгмийн даатгалын байгууллага бидэнд мэдлэг, ойлголт өгөх сургалт, сурталчилгаа явуулдаггүй
- Надад хэрэг болохгүй г.м

Судалгааны явцад нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдлын талаар судалгаанд хамрагдагсдаас асуухад 32.1 хувь нь тэтгэвэр авахад, 21.7 хувь нь тэтгэмж авахад, 14.8 хувь нь осол гэмтлийн даатгал авахад хэрэгтэй гэсэн бол 31.4 хувь нь нийгмийн даатгалын ач холбогдлыг

мэдэхгүй гэж хариулсан байна. Тэдгээрийн нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж буй эсэхийг тодорхойлохоор оролдсон боловч бараг хамрагдахгүй байгаа гэснээс өөр хариулт өгөөгүй ажээ. Харин нийгмийн халамжийн ямар үйлчилгээ шаардлагатай байна вэ? гэсэн асуултанд тэдний 58.1 хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээ шаардлагагүй гэж хариулсан бол, 9 хувь нь өндөр насны тэтгэмж, 6.4 хувь хүүхдийн мөнгөн тэтгэмж, 6.9 хувь нь нэн ядуу иргэдийн тэтгэмж, 2.5 хувь нь хүүхэд асарсаны тэтгэмж шаардлагатай гэж хариулжээ.

Дээр дурдсан хариултуудаас үзэхэд хувиараа ашигт малтмал олборлогч иргэд нийгмийн халамж үйлчилгээнд хангалтгүй хамрагддаг ба түүний талаарх ойлголт, мэдлэг тааруу байна гэсэн дүгнэлт гарч байна.

Нөгөө талаар нийгмийн халамж үйлчилгээнд, ялангуяа нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамрагдахын ач холбогдол, давуу талыг сурталчлан таниулах үйл ажиллагааг орон нутгийн засаг захиргаанаас сайтар зохион байгуулах шаардлагатай болох нь дээрх дүгнэлтүүдээс харагдаж байгаа болно.

6.3. Хүн амын орлогын албан татвар төлсөн байдал.

Монгол Улсын нэгдсэн төсөв нь Монгол Улсын төсөв, орон нутгийн төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрддэг бөгөөд төсвийн орлого нь урсгал орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлогоос бүрдэнэ. Урсгал орлого нь татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ. Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар ордог билээ.

Бид хувиараа ашигт малтмал олборлогчдын орон нутгийн төсөвт оруулж байгаа хүн амын орлогын албан татвар төлөлт ба тэдгээрийн нийгмийн хариуцлагын өнөөгийн байдлын талаар судалж үзсэн. Тэдгээрийн орлогын албан татвараа төлсөн байдлыг орон нутагт явуулсан суурь судалгааны үр дүнгээс үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Хувиараа ашигт малтмал олборлогчдоос ХАОАТ төлдөг иргэдийн хувь хэмжээ: (хувиар)

Үзүүлэлт	Бигэр сум	Борнуур сум	Жаргалант сум	Уянга сум	дундаж
Хувиараа ашигт малтмал олборлогчдоос ХАОАТ төлдөг ХАМО иргэдийн хувь	0	10,0	4,0	0	3,5

Хүснэгтээс үзэхэд Борнуур сумын хувиараа ашигт малтмал олборлогчдын 10,0 хувь нь ХАОАТ төлдөг, Жаргалант сумын хувиараа ашигт малтмал олборлогчдын 4,0 хувь нь ХАОАТ төлдөг, Бигэр, Уянга зэрэг сумдын хувиараа ашигт малтмал олборлогчид татвар огт төлдөггүй болох нь харагдаж байгаа ба дундажаар нийт хувиараа ашигт малтмал олборлогчдын 3,5 хувь нь хүн амын орлогын албан татварт хамрагдаж байгаа гэсэн дүгнэлт гаргаж болохоор байна.

Хувиараа ашигт малтмал олборлогчдоос алт олборлолтынхоо орлогоос орлогын албан татвар төлдөг эсэх талаар судлахад 96 хувь нь орлогын албан татвараа төлдөггүй болох нь харагдсан бөгөөд ямар шалтгааны улмаас ХАОАТ-аа төлдөггүй талаар тэднээс лавлахад 55 хувь нь энэ талаар мэдээлэл байхгүй, 37 хувь нь төлбөрийн чадваргүй, 8 хувь нь төлөх аргаа мэдэхгүй, 2 хувь нь завгүй гэж хариулсан байна.

Дээрх байдал, хариултуудаас дүгнэлт хийхэд хувиараа ашигт малтмал олборлогчдын 96,5 хувь нь ХАОАТ төлдөггүй бөгөөд тэд нийгмийн өмнө хүлээсэн үүргээ туйлын хангалтгүй биелүүлж байна гэж үзэхээс өөр аргагүй юм.

Нөгөө талаар судалгаанд оролцогчдын 55 хувь нь ХАОАТ-ын талаар мэдээлэл байхгүй, 8 хувь нь төлөх аргаа мэдэхгүй, 2 хувь нь завгүй гэсэн хариулт өгсөн байгаагаас үзэхэд орон нутгийн татварын асуудал хариуцсан ажилтнуудын зүгээс татварын бааз суурийг өргөжүүлэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа хангалтгүй байна гэсэн дүгнэлт гарч байна.

Цаашид хувиараа ашигт малтмал олборлогчдоос хүн амын орлогын албан татварт хамрагдах хувь хэмжээг нэмэгдүүлэх, тэдгээрт “Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн хүрээнд ноогдох татварыг тухай бүр нь төлж байх сэтгэхүй, ухамсар бий болгох талаар орон нутгийн засаг захиргаанаас тодорхой ажил зохион байгуулах шаардлагатай юм.

Мөн хувиараа ашигт малтмал олборлогч иргэд, албан бус нөхөрлөлүүдээр гишүүнчлэгдсэн төрийн бус байгууллагууд болон тэдгээрийн үйл ажиллагааг дэмжигч байгууллагууд нийгмийн хариуцлагын талаар хувиараа ашигт малтмал олборлогчдод мэдлэг, ойлголт өгөх сургалт, сурталчилгааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах шаардлага улам бүр өсөн нэмэгдэж байгааг анхааралдаа авах хэрэгтэй байгаа болно.

Долдугаар бүлэг. Хувиараа ашигт малтмал олборлогчдын ажлын байрны нөхцөл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, гэмт хэрэг, зөрчил

7.1. Хувиараа ашигт малтмал олборлогчдын ажлын байрны нөхцөл.

Уул уурхайн олборлох үйлдвэрлэлд тавигдах нөхцөл, шаардлагуудыг Монгол Улсын стандарт, техникийн шаардлагуудаар тодорхойлж гаргасан байдаг.



Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд оролцож байгаа иргэд өөрсдийгөө ажлын байрны тав тух, аюулгүй ажиллагааны наад захын хэрэгцээ шаардлагад нийцээгүй, хамгийн их эрсдэл дагуулсан маш хүнд хэцүү нөхцөл байдалд ажилладаг гэдгээ мэддэг ч үүнээс өөр сонголт, орлого олох боломж байхгүй учраас энэхүү ажлыг хийж байна гэж үздэг нь судалгааны үр дүнгээс харагдаж байгаа болно. Алтны үндсэн ордод ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулдаг Төв аймгийн Борнуур сумын хувиараа ашигт малтмал олборлогчдын ажлын байрны нөхцлийн талаар тэдний санал сэтгэгдлийг жишээлэн авч харуулбаас:

Ажлын байрны хүчин зүйлийн түвшин

№	Хүчин зүйлс	Судалгаанд оролцогчдын тоо	Их /муу/		Дунд зэрэг		Бага /сайн/	
			тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1	Тоос	168	110	66,5	56	33,5	-	-
2	Шуугиан	168	13	7,9	93	55,4	62	36,7
3	Доржилт	168	8	5	88	52,2	72	42,8
4	Агаарын хүрэлцээ	168	83	49,7	48	28,4	37	21,9
5	Хортой хий бодис	168	10	6,1	37	22,3	121	71,9

6	Гэрлийн хүрэлцээ	168	12,8	76,3	22	12,9	18	10,8
7	Биеийн хүчний ачаалал	168	109	65,1	53	31,7	5	3,2
8	Сэтгэл санааны дарамт	168	62	36,7	59	34,9	48	28,4
9	Согтууруулах ундаа хэрэглэх	168	18	10,5	71	42,4	79	47,1
10	Ажлын цагийн үргэлжлэл	168	120	71,6	48	28,4	-	-

Эндээс үзэхэд ажлын байрны хүчин зүйлсүүдээс гэрлийн хүрэлцээ муу гэж оролцогчдын 76,3 хувь, ажлын цагийн үргэлжлэл их гэж 71,6 хувь, тоос их гэж 66,5 хувь, биеийн хүчний ачаалал их гэж 65,1 хувь, агаарын хүрэлцээ муу гэж 49,7 хувь гэж тус тус хариулсан байна. Эдгээр хүчин зүйлсүүдийг хамгийн хүнд гэж тэд үзэж байгаа боловч шуугиан, доргилт, сэтгэл санааны дарамт зэргийг дунд зэрэгт оруулж, хортой хий ба бодисын аюулт уршиг, согтууруулах ундаа хэрэглэх зэрэг хүчин зүйлүүдийн нөлөөлөл бага гэж оролцогчид үздэг ажээ.

ТоБУТ-тэй хамтран ажилладаг Борнуур, Жаргалант зэрэг сумдын хувиараа ашигт малтмал олборлогчид бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтаар ажиллаж, хуримтлал үүсгэн ажлын байрныхаа нөхцөлийг сайжруулах талаар үе шаттай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж эхэлсэн нь сайшаалтай. Гэхдээ хувиараа ашигт малтмал олборлогч нийт иргэн ийм арга хэмжээ авч байна уу гэвэл бас үгүй юм.

Бусад орон нутгийн хувиараа ашигт малтмал олборлогчид бичил уурхайн хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд бүртгэгдээгүй нөхөрлөлийн бүтэц, зохион байгуулалтанд ороогүй байгааг учраас тэд бусдаас аль болох өрсөж их хэмжээний олборлолт явуулан ашиг олохыг хичээн ажиллаж байгаа нь өөрсдийгөө эрсдэлд оруулах нөхцөлийг бүрдүүлж байна гэж үзэхээс өөр аргагүй.

Алтны үндсэн ордод ажилладаг хувиараа ашигт малтмал олборлогчдын ажлын байрны нөхцөл ийм байхад шороон ордод ажилладаг хувиараа ашигт малтмал олборлогчид их тоосжилттой, агаарын хүрэлцээ муу, чийгтэй, хүйтэн зэрэг хүнд орчин нөхцөлд ажилладаг байна.

Эдгээрээс дүгнэлт хийхэд хувиараа ашигт малтмал олборлогчид өөрсдийн ажлын байрыг хадгалах, ажиллах нөхцөлөө сайжруулах талаар санаачлага муу байгаагаас гадна энэ талаарх мэдлэг, ойлголт нь тун хангалтгүй байна.

Уул уурхайн олборлох үйлдвэрлэл эрхлэгчдэд тавигддаг шаардлагуудыг хувиараа ашигт малтмал олборлогчдод тавихад хүндрэлтэйгээс гадна стандарт, техникийн шаардлагуудыг хэрэгжүүлэх санхүүгийн боломж нөхцөл ч тэдний хувьд хангалтгүй байх нь ойлгомжтой. Гэсэн ч хувиараа ашигт малтмал олборлогчид өөрсдийн үйл ажиллагаанд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны наад захын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай юм.

Орон нутагт явуулсан нийгэм эдийн засгийн судалгаагаар тодорхойлогдсон хувиараа ашигт малтмал олборлогчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны өнөөгийн байдлыг авч үзье.

Алтны шороон ордод ажилладаг хувиараа ашигт малтмал олборлогчид нийтийг хамгаалах ямар ч хэрэгсэл байхгүй, харин хувийн хамгаалах хэрэгслийн хувьд гэвэл зайлшгүй хэрэглэхээс аргагүйд тэртэй тэргүй хүрдэг усны гутал, резинэн бээлий, амны хаалт, ажлын бээлий зэргийг хэрэглэдэг байна.

Түүнээс гадна ажлын багаж зэвсгийн хувьд судалгаанд хамрагдсан нийт ХАМО нарын 88.7 хувь нь хүрз, 35.5 хувь нь лоом, 41.4 хувь нь жоотуу, 52.2 хувь нь хувин, 41.9 хувь нь түмпэн, 17.2 хувь нь шуудай 11.3 хувь нь шигшүүр, 35.5 хувь нь сков, 1.5 хувь нь усны насос буюу памп, 4.4 хувь нь резин, 0.5 хувь нь шаланк, 7.9 хувь нь усан буу, 3.9 хувь нь хуурай угаагч, 1.5 хувь нь пайжгар гэж хариулснаас үзэхэд хамгийн их хэрэглэдэг багаж хэрэгсэлд хүрз, лоом, жоотуу, түмпэн шуудай, сков зэрэг ордог ажээ.

Судалгаанд хамрагдагсдаас ямар техник, багаж таны ажлыг хөнгөвчилдэг вэ? гэсэн асуултанд хамгийн их буюу 39.9 хувь нь хүрз, 20.7 усан буу, 16.3 хувь нь сков зэргийг хамгийн их ажил хөнгөвчилдэг багаж хэрэгсэл гэж нэрлэсэн бөгөөд экскаватор, бульдозер, усан насос, шлюзыг хэрэглэх сонирхол байгаа боловч үнэтэй, худалдаж авч дийлдэггүй учраас хямд, овор багатай хэрэгслүүдийг хэрэглэдэг нь болох нь ажиглагдсан.

Үндсэн ордод ажилладаг хувиараа ашигт малтмал олборлогчдын хувьд тоос шороотой нөхцөлд ажилладаг учир тэдний хувьд хамгийн хэрэгцээтэй зүйл нь маск байдаг хэдий ч агааргүй, битүү орчинд ажилладаг болохоор тэр болгон шаардлагад нийцсэн маскыг байнга, цэвэр хэрэглэх, худалдан авах боломжгүй байдаг учраас өдөр болгон хэрэглээд байж чаддаггүй. Хамгаалах нүдний шил, усны гутал, бэхлэгч, ажлын гутал, бээлий, каск зэрэг хөдөлмөр хамгааллын багаж хэрэгсэл, хувцас зэрэг нь тэдний ажилд маш их хэрэгтэй байдгаас гадна малгайн гэрэл, бэхэлгээний олс зэрэг багаж нь тэдний үйл ажиллагаанд зайлшгүй чухал шаардлагатай байдаг учир байнга хэрэглэдэг гэжээ.

Алтны үндсэн ордын хувьд илүү механикжсан байдал ажиглагдсан бөгөөд агааржуулах зорилгоор компрессор, агааржуулах төхөөрөмж зэргийг ашиглаж байна. Үндсэн ордод тохиолддог бас нэгэн өвөрмөц бөгөөд шийдэхэд хүндрэлтэй, эрсдэлтэй зүйл бол тэсэлгээний асуудал болох нь судалгааны явцад харагдаж байлаа. Хад, чулууг хагалж бутлахдаа тэсэлгээг хэнээр хийлгэдэг талаарх асуултанд оролцогчдын 79,0 хувь нь туршлагатай хувиараа алт олборлогч нараар хийлгэдэг гэсэн бол үлдсэн хувь нь тэсэлгээний эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гэж хариулсан боловч аль компаниас ихэвчлэн үйлчилгээ авдаг талаар тодруулахад үйлчилгээ үзүүлдэг компанийхаа нэрийг хэлж мэдэхгүй байсан ажээ. Эндээс үзэхэд бичил уурхайн салбарт тэсэлгээний бодис нийлүүлдэг, борлуулдаг нууц сүлжээ бий болжээ гэж үзэж болох юм.

Мөн тэсэлгээтэй холбоотойгоор үйлчилгээний хөлс өндөр, цагдаа болон мэргэжлийн байгууллагад шалгагдах магадлал их, тэсрэх бодис нь хууль бус учир олдоц муу, дээр нь хадгалахад аюултай байдаг зэрэг бэрхшээлүүдийг нэрлэсэн нь дээр дурдсан нууц сүлжээ бодитойгоор ажилладаг болохыг илтгэж байна.

7.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт зөрчсөнөөс гардаг осол аваар.



Хувиараа алт олборлогч иргэд давчуу, харанхуй, хүйтэн ,тохиромжгүй нөхцөлд биеийн хүчний хүнд хөдөлмөр хийдэг бөгөөд нэг хэвийн хөдөлгөөний давталт ихтэй, биед тохиромжгүй, албадмал байрлалд, давчуу зайнд ажилладаг, халтирах, тээглэх унах, юманд цохиулах, даруулах, иртэй болон хөдөлгөөнтэй багаж хэрэгсэлтэй харьцах үед хавчуулагдах, зүсэгдэх зэрэг осол гэмтэлд өртөх эрсдэл өндөртэй байдаг ажээ.

Тэд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны наад захын дүрэм журмын талаарх мэдлэг, ойлголт байхгүй учир тэдгээрийг зөрчсөнөөс болж осол аваарт орох нь цөөнгүй байгааг орон нутагт явуулсан судалгаа нотлож байна.

Хувиараа ашигт малтмал олборлогчдод тохиолдож байгаа осол аваарын байдал (хувиар)

Үзүүлэлт	Бигэр сум	Борнуур сум	Жаргалант сум	Уянга сум	Дундаж
ХАМО иргэдийн дунд тохиолдож байгаа осол аваарын байдал	13,7	12,5	10,3	85,3	30,4

Дээрх үр дүнгээс үзэхэд судалгаанд оролцогчдын дундажаар 30,4 хувь нь ямар нэг байдлаар хөдөлмөрийн аюулгүй ажиллагаатай холбоотойгоор осол аваарт орж байсан болох нь харагдаж байгаагаас гадна цаашид ч энэ байдал дахин тохиолдох магадлалтай байна. Жил ирэх тусам алтны нөөц буурч, хувиараа ашигт малтмал олборлогч нар илүү гүнд ажиллах нь тодорхой.

Борнуур, Жаргалант сумдын хувиараа ашигт малтмал олборлогчдын хувьд тэдгээрт тохиолдож байгаа осол гэмтлийн тоо харьцангуй бага байгаа бол Бигэр, Уянга зэрэг сумдын хувиараа ашигт малтмал олборлогчдод осол, гэмтэл, аваар нэлээд олон тохиолдож байсан нь дээрх хүснэгтэд үзүүлсэн судалгаанаас харагдаж байгаа ажээ.

Бигэр, Уянга зэрэг сумдын хувиараа ашигт малтмал олборлогчдод тохиолдож буй осол, гэмтэл, аваар өндөр үзүүлэлттэй байгаа шалтгаануудыг дараах байдлаар нэрлэсэн байна. Үүнд:

- удирдлага, зохион байгуулалт хангалтгүйгээс хаа таарсан газар олборлолт явуулдаг,
- олборлолт явуулах хөдөлмөр аюулгүй ажиллагааны дүрэм, заавруудыг мэдэхгүй, техник, хэрэгсэл дутмаг, ашигт малтмал олборлох талаар мэдлэг ойлголтгүй хүмүүс энэхүү үйл ажиллагаанд олноор оролцдог,
- их хэмжээний ашигт малтмал олборлохын тулд өрсөлдөж хөдөлмөр, аюулгүй ажиллагааны дүрэм журмуудыг зөрчдөг гэжээ.

Зарим тоо баримтаас...

Уянга сумын хүн эмнэлгийн сүүлийн 3 жилийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн тухай дүн бүртгэлийн мэдээнээс:

- Бэртэл гэмтэл, хордлогын тохиолдол 2007 онд 97, 2008 онд 123, 2009 онд 257 гарч эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан
- 2009 оны хувьд гэмтэл бэртлийн тохиолдол 2007 оныхоос 1,3 дахин, 2008 оныхоос 2 дахин тус тус өсчээ.

Мөн судалгааны явцад ТоБУТ-ийн хүрээнд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сургалт, хичээлүүдэд сууж байсан хэдий ч нөхөрлөлийн бүх гишүүд нэгдсэн ойлголтод **хүрээгүй**, бүрэн зохион байгуулалтад орж чадаагүй, сурсан зүйлээ амьдрал дээр төдийлөн сайн оновчтой хэрэглэж чадахгүй байгаа тухайгаа дурьдаж байжээ.

Бид манай орны уул уурхайн олборлолтын салбарт сүүлийн жилүүдэд тохиолдож байсан осол аваарын талаарх мэдээллийг энд орууллаа.

Уул уурхайн аврах албаны мэдээллээс :

№	Ашигт малтмалын нэр төрөл	Үзүүлэлт	2006 онд	2007 онд	2008 онд	2009 онд	Дүн
1	Алт	Амь аврагдсан	26	11	17	36	90
		Нас барсан	8	6	9	14	37
2	Жонш	Амь аврагдсан	15	7	21	18	61
		Нас барсан	9	2	6	4	21
3	Нүүрс	Амь аврагдсан	23	42	34	15	114
		Нас барсан	9	19	13	2	43

Уул уурхайн олборлох салбарын хэмжээнд гарсан осол аваарын нийт тоог харуулсан энэхүү мэдээллээс үзэхэд нүүрс олборлолтын явцад гардаг осол аваарын тоо хамгийн олон, түүний дараагаар жонш, алт олборлох үйл ажиллагаа орж байгаа бөгөөд энэхүү нэгдсэн мэдээлэл дотор хувиараа ашигт малтмал олборлохтой холбоотой осол аваарын мэдээлэл мөн багтсан болно.

Уул уурхайн аврах албаны мэргэжилтнүүд олборлолтын явцад осол аваар гарахад хүргэж байгаа зөрчлүүдийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Уурхайн налуугийн градус их буюу босоо
- Малталтын хөндлөн огтлолын талбай бага, мөн их байх
- Бэхэлгээ муу байх
- Агааржуулах систем байхгүй буюу байсан ч стандарт бус
- Нөөц гарцгүй мухар байх
- Малталтын урт хэт их байх
- Малталт хоорондын зай бага байх
- Давхар малталт хөөхдөө аюулгүйн зай барихгүй байх
- Малталт хоорондох зайг хэт ойрхон эхлэх, давхаргуудад хүрэнгүүт өрсөн ухаж эхлэх.

Эдгээр зөрчлүүд хувиараа ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагаанд нэлээд түлхүү байгаа нь нууц биш юм.

7.3. Хувиараа ашигт малтмал олборлохтой холбоотой гэмт хэрэг зөрчил.

Орон нутагт байгалийн нөөц, баялаг ашиглахтай холбоотой гарч буй зөрчил маргаанууд хувь хүмүүсийн хоорондын асуудлаас эхлээд хэд хэдэн талуудыг хамарсан төвөгтэй хэлбэрээр илэрч байгаагаас гадна хувиараа ашигт малтмал олборлохтой холбоотойгоор орон нутагт гэмт хэрэг, зөрчлийн гарах явдал түгээмэл байгааг судалгааны үр дүнгээс үзэж болно. Гэхдээ гэмт хэрэг зөрчлийн дийлэнх хэсэг нь бичил уурхайн хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд бус хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж байгаа газар нутгуудад тохиолдож байгаагаараа онцлогтой.

Хувиараа ашигт малтмал олборлохтой холбоотой гэмт хэрэг зөрчлийн байдал:

Үзүүлэлт	Бигэр сум	Борнуур сум	Жаргалант сум	Уянга сум	дундаж
Хувиараа алт олборлож буй газарт гэмт хэрэг зөрчил гардаг гэж мэдээлсэн ХАМО иргэдийн хувь	96,7	1,9	1,2	93,0	48,2
Хувиараа алт олборлогчид ба бусад талуудын хооронд зөрчил маргаан гардаг	95,0	5,2	3,6	98,0	50,5

гэж мэдээлсэн ХАМО иргэдийн хувь					
----------------------------------	--	--	--	--	--

Дээрх хүснэгтээс үзэхэд хувиараа ашигт малтмал олборлож буй газарт гэмт хэрэг зөрчил гардаг гэж судалгаанд оролцогчдын 48,2 хувь нь, хувиараа ашигт малтмал олборлогчид, ба бусад талуудын хооронд зөрчил маргаан гардаг гэж оролцогчдын 50,5 хувь нь мэдээлжээ. Судалгаанд хамрагдсан сумдаар нь авч үзэхэд Борнуур, Жаргалант сумдад ашигт малтмал олборлож байгаа газарт гарч байгаа гэмт хэрэг зөрчлийн хэмжээ болон талуудын хоорондын зөрчил маргаан маш бага, харин Бигэр, Уянга зэрэг сумдад харьцангуй өндөр үзүүлэлттэй гарчээ.

Үүнээс үзэхэд бичил уурхайн хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд зөвшөөрөөгүй газар нутагт зохион байгуулалтгүйгээр ашигт малтмал олборлож буй хэсэгт гэмт хэрэг, нийгмийн янз бүрийн бүлгүүдийн хоорондын маргаан зөрчил түгээмэл, хурц хэлбэртэй байна гэж үзэж болох юм. Гэмт хэрэг зөрчлийн дийлэнх хэсгийг хулгай, хэрүүл маргаан, зодоон, архидалт, дээрэм, биеэ үнэлэх явдал эзэлж байгааг дараах баримтаар нотолж болно.

Зарим тоо баримтаас...

Говь-Алтай аймгийн Бигэр суманд алт олборлохтой холбоотойгоор гарсан гэмт хэрэг зөрчлийн талаарх мэдээлэл:

- 61,4 хувийг хулгай,
- 45,5 хувийг хэрүүл маргаан, зодоон,
- 27,6 хувийг дээрэм,
- 19,7 хувийг биеэ үнэлэлт эзэлж байсан

Харин хувиараа ашигт малтмал олборлогчид ба бусад талуудын хооронд зөрчил маргаан үүсгэж байгаа шалтгаанууд нь байгаль орчны доройтол, нөхөн сэргээлт, ашигт малтмал олборлох газрын зөвшөөрөл, бэлчээр, гарц ихтэй газар булаалдах, уурхай дээрх эмх журам, хөдөлмөрийн хуваарь, ашиг орлого хуваарилалт зэрэгтэй холбоотой байдаг ажээ. Бичил уурхайн хууль эрх зүйн зохицуулалтын бус хүрээнд ашигт малтмал олборлох үйл ажиллагаа нь орон нутагт ажлын байр хомс, амьжиргааны түвшин доогуур ядуурал, ажилгүйдэл их байгаатай холбоотой учраас иргэдийн зүгээс аргагүйн эрхэнд явуулж буй үйл ажиллагааг буруутгах аргагүй юм. Гэвч тэдгээр хувиараа ашигт малтмал олборлогчид өөрсдийн эрх, ашиг сонирхолыг хангахдаа хүрээлэн буй орчин, нийгмийн бусад бүлгийнхний эрх ашгийг хөндөх эрхгүй гэдгээ ойлгож хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа явуулах шаардлагатай юм гэсэн дүгнэлт гарч байна.

Наймдугаар бүлэг. Хувиараа ашигт малтмал олборлогч иргэд бүтэц зохион байгуулалтанд орж буй хэлбэрүүд

8.1. Бүтэц зохион байгуулалтын хэлбэрүүд

Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн амьжиргааг тогтворжуулах, тэдгээрийн ажлын байрыг хадгалах хөрс суурь нь юуны өмнө тэднийг бичил уурхайн эрх зүйн зохицуулалтын хүрээнд бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтанд оруулах явдал юм. Иймээс хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн хамтын зохион байгуулалтанд оролцох чадавхийг хөгжүүлэх, тэдгээрийн ашигт малтмалын нөөцийг зөв зохистой, тогтвортой ашиглах чадварыг дээшлүүлэх гол хүчин зүйл нь тэдгээрийн хүч хөдөлмөрийг зөв хорших, хамтын ажиллагааг сайжруулах талаар хэрхэн зөв залж чиглүүлэхээс шууд шалтгаална.



Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг иргэд ямар бүтэц зохион байгуулалттайгаар эрхэлж байгаа талаарх мэдээллийг орон нутагт явуулсан суурь судалгааны үр дүнгээс үзэхэд ганц ганцаараа эсвэл ах дүү, хамаатан садан, найз нөхдийн хүрээнд албан бусаар нэг баг, бригад үүсгэн ажиллах, бүртгэгдээгүй нөхөрлөл байгуулан ажиллаж байгаа зэрэг бүтэц, зохион байгуулалтын олон хэлбэрүүд байгаа нь тогтоогджээ.

Хувиараа ашигт малтмал олборлогчдын бүтэц зохион байгуулалтын хэлбэрүүд:

	Бигэр сум	Борнуур сум	Жаргалант сум	Уянга сум
ХАМО иргэдийн бүтэц зохион байгуулалтын хэлбэрүүд	• Бүлэг • Ганцаар	• Бүртгэгдээгүй нөхөрлөл • Төрийн бус байгууллага	• Бүртгэгдээгүй нөхөрлөл • Төрийн бус байгууллага	• Нэг гал буюу бригад • Ганцаар

Дээрх хүснэгтээс Борнуур, Жаргалант зэрэг сумдын хувиараа ашигт малтмал олборлогчид бүртгэгдээгүй нөхөрлөл, төрийн бус байгууллагын хэлбэрээр, Бигэр, Уянга зэрэг сумдын хувиараа ашигт малтмал олборлогчид ганц, ганцаараа эсвэл албан бус бүлэг, нэг гал буюу бригадын бүтэц зохион байгуулалтаар ажиллаж байгаа ажээ.

Албан бус бүлэг, нэг гал буюу бригадын бүтэц зохион байгуулалтаар ажиллаж байгаа хувиараа ашигт малтмал олборлогчид нэг гэрт амьдарч, нэг тогооноос хооллож, хамтдаа нүх ухах, алтаа угаах зэрэг ажлыг хоорондоо тохиролцон, хуваарилж ажиллаад олсон орлогоо тэнцүү хуваах, хийсэн ажил, оруулсан хөрөнгө хүчнийхээ хувь хэмжээгээр хуваан авах зарчмаар ажилладаг.

Харин Иргэний хуулийн 481.1 –д заасны дагуу хувиараа ашигт малтмал олборлогчид хамтран ажиллах гэрээ байгуулан бүртгэгдээгүй нөхөрлөл хэлбэрээр зохион байгуулагдаж алт олборлох газрын асуудлаар сумын засаг даргатай гэрээ байгуулан ашигт малтмалыг гар багажаар болон бага оврын техник тоног төхөөрөмж ашиглан алт олборлох үйл ажиллагаа явуулж байна.

Хувиараа ашигт малтмал олборлогч иргэд бүртгэгдээгүй нөхөрлөлийг хөдөлмөрөө хоршин ашиг олох зорилгоор байгуулдаг бөгөөд энэ нь гишүүнчлэлтэй, хуулийн этгээдийн эрхгүй, хамтын хөдөлмөрийн хэлбэр юм.

Нөхөрлөлийн гишүүд нь дараахь шаардлагыг хангах ёстой байдаг.

- Монгол Улсын иргэн байх
- 18 насанд хүрсэн байх
- Тухайн сумын оршин суугч байх
- Орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй иргэний орлогын албан татвар төлөгчийн гэрчилгээ авсан байх

- Эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдсан байх
- Нөхөрлөлийн гишүүн зөвхөн нэг нөхөрлөлд хамаарагддаг байх

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам (Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоол)-д зааснаар нөхөрлөлийн гишүүдийн тоо 5-аас дээш байхаар заажээ. Нөхөрлөлийн гишүүд хөдөлмөрөө хорших, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг мөрдөх, ажил үүргээ хуваарилах, ашиг орлогоо хуваах, дундын сан байгуулах, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, дотоод хяналт тогтоох, шаардлага тавих, аливаа зөрчлийг арилгах зэрэгт хамгийн тохиромжтой нөхөрлөлийн бүтэц бол 8-12 хүртэл гишүүнчлэлтэй байх явдал гэж судалгаанд оролцогчид тодорхойлж байжээ.

Дээр дурдсан хэлбэрүүдээс гадна хувиараа ашигт малтмал олборлогчдын үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагууд нь тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, гишүүд, орон нутгийн төр, засаг захиргааны хооронд холбогч гүүр болох, гишүүддээ эрх зүйн болон технологийн талаар мэдээлэл дамжуулах, нийгмийн чиглэлтэй үйл ажиллагааг нь зохион байгуулах зэрэг үүрэг гүйцэтгэдэг байна.

8.2. Харилцаа холбоо

Хувиараа алт олборлох ажил нь эрсдэл ихтэй, өдрийн ихэнх цагийг хүнд, хортой нөхцөлд өнгөрүүлэх шаардлагатай болдог учраас бусадтай хүч, нөөцөө нэгтгэх, хамтрах асуудалд судалгаанд оролцсон иргэд ихээхэн ач холбогдол өгч, санал нийлдэг тухайгаа илэрхийлж байлаа. Хэдийгээр хувиараа ашигт малтмал олборлогчид нэг гал, бригадын зохион байгуулалтаар ажиллаж байгаа боловч бусад албан бус бүлгүүдтэй туршлага солилцох, өөрсдийн эрх ашгийг хамгаалах зэрэг асуудлаар харилцаа холбоо тогтоох сэдэл, санаачлага гаргахаас илүүтэй зөвхөн тухайн газраас хөөгдөж туугдахаас өрсөж яаж хурдан хугацаанд ашиг олох талаар бүх анхаарлаа хандуулж ажилладаг болох нь судалгаагаар тогтоогдсон. Мөн нэг гал, бригад нь түр зуур оршин тогтноод тарж бутрах нь түгээмэл байдаг бол бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтаар ажиллаж байгаа хувиараа ашигт малтмал олборлогчид өөрсдийн эрх ашгийг хамгаалах, бусад нөхөрлөлүүдтэй харилцан туршлага солилцох, хүчээ нэгтгэх, зарим үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх зэргээр харилцаа холбоо тогтоож тогтвортой ажилладаг онцлогтой.

Олон жилийн турш хууль бус гэж үзэн шахаж гадуурхдаг, үгүйсгэдэг нийгмийн сэтгэл зүйн тогтсон хандлагыг өөрчлөхөд хувиараа алт олборлогч иргэдээр гишүүнчлэгдсэн бүртгэгдээгүй нөхөрлөл, төрийн бус байгууллагын хэлбэрүүд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Хувиараа ашигт малтмал олборлогчид хоорондын харилцаа холбоогоо хөгжүүлэх, харилцан туршлага солилцох, өөрсдийн эрх ашгийг хамгаалах үндсэний хэмжээний дээвэр байгууллага байгуулахыг эрмэлздэг болох нь орон нутагт хийсэн судалгааны явцад харагдсан байна.

Төрийн бус байгууллагын талаарх ХАМО иргэдийн сэтгэгдэл: (хувиар)

	Борнуур сум	Жаргалант сум	Дундаж
ХАМО иргэдийн үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагын зорилго, үйл ажиллагааг дэмждэг ХАМО иргэдийн эзлэх хувь	85,0	92,0	88,5
Хувиараа ашигт малтмал олборлогчдын эрх ашгийг хамгаалах үндсэний хэмжээний байгууллага байх шаардлагатай гэж үзэгсдийн эзлэх хувь	78,3	68,0	73,2

Дээрх хүснэгтээс үзэхэд судалгаанд оролцогчдын **88,5** хувь нь хувиараа ашигт малтмал олборлогчдын үүсгэл санаачлагаар байгуулагдсан төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмждэг, **73,2** хувь өөрсдийн эрх ашгийг хамгаалах үндэсний хэмжээний байгууллага байгуулах шаардлагатай гэж үздэг ажээ.

8.3. Хамтын ажиллагаа ба төрийн бус байгууллагуудын бүтэц зохион байгуулалт

Хувиараа ашигт малтмал олборлогчдын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бүртгэгдээгүй нөхөрлөлүүд, төрийн бус байгууллагууд томоохон үүрэг гүйцэтгэж байгаа нь судалгаанд оролцогчдын өгсөн хариултуудаар батлагдаж байсан. Эдгээрийг байгуулан ажилласнаар орон нутагт хувиараа ашигт малтмал олборлохтой холбоотой гардаг зөрчил, маргаануудыг холбогдох талуудын оролцоотойгоор зөвшилцөн шийдвэрлэх боломжуудыг бий болгож, харилцан үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх урьдчилсан нөхцөлүүдийг бүрдүүлсэн гэж үзэж болох юм.

Бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтаар ажиллаж байгаа хувиараа ашигт малтмал олборлогчдын хамтын ажиллагааны давуу талууд нь дараах байдлаар тодорхойлогдож байна. Үүнд:

- Гишүүдийн аюулгүй байдлыг хангах
- Хамт олонч, багаар ажиллах сэтгэлгээг хөгжүүлэх
- Ажлын байрны тав тухтай байдлыг хангах
- Эмэгтэйчүүдийн оролцоо, хөдөлмөр хуваарилалтыг шударга зохион байгуулах
- Ажлын ачаалал, стрессийг хамтран үүрэх, нэгж гишүүнд ирэх дарамтыг хөнгөлөх
- Алт олборлох тэгш боломжийг гишүүдэд олгох
- Олборлолт явуулах газрыг булаацалдах, зөрчилдөх шалтгааныг бууруулах
- Ашигт малтмал олборлохтой холбоотой зөрчил, маргаануудыг зөвшилцөн шийдвэрлэх боломжуудыг бий болгох
- Гишүүдийн гэр бүлийн стресс, түгшүүрийг багасгах
- Орон нутгийн иргэдийн хоорондын харилцаа, итгэлцлийг нэмэгдүүлэх
- Хувиараа ашигт малтмал олборлогч хүн бүрийг эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамруулах, хүн амын орлогын албан татварыг хууль журмын дагуу төлдөг болгох боломжуудыг нээх,
- Орон нутгийн засаг захиргаанаас хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааг ажиглах, хянах, зохион байгуулах ажлыг хөнгөвчлөх
- Гишүүн бүр хөдөлмөрийн хөлсөө шударга, тэнцвэртэй хуваарилах нөхцөлөөр хангагдах зэрэг болно.

Хувиараа ашигт малтмал олборлогчдын үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагууд нь дараах бүтэц зохион байгуулалтай байна. Үүнд:

- Эрх барих дээд байгууллага нь Бүх гишүүдийн хурал
- Бүх гишүүдийн хурлаас сонгогдсон Удирдах зөвлөл ба хяналтын зөвлөл
- Удирдах зөвлөлийн дарга нь ТББ-ын тэргүүний үүрэг гүйцэтгэдэг
- Гүйцэтгэх алба

Мөн гүйцэтгэх албаны дэргэд орон тооны бус дараах дэд зөвлөлүүд ажилладаг байна. Үүнд:

- Техникийн дэд зөвлөл
- Нийгмийн дэд зөвлөл
- Байгууллагын хөгжлийг дэмжих дэд зөвлөл
- Бага орлоготой иргэдийг дэмжих дэд зөвлөл

Хувиараа алт олборлогч иргэдийн зохион байгуулалт, нэгдмэл хэрэгцээ, асуудлуудыг үндэслэн байгуулагдсан ТББ-ын мөн чанар, онцлог нь төрийн бус байгууллагын статусаас

илүүтэйгээр олон нийтийн үүсгэл санаачлагын байгууллагын /community based organization/ хэлбэрээр оршин тогтнох нь тогтвортой байдлыг хангах, нийтийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд нийцтэй юм.

Олон нийтийн үүсгэл санаачлагын байгууллагын зохион байгуулалтын үндсэн зарчим нь “нэгж гишүүнээс нэгж санал” буюу тодорхой шийдвэрийг гаргахад гишүүн бүрийн саналыг олон төрлийн арга хэлбэрээр судлах, тусгах, цөөнхийн эрх, эрх чөлөөг хүндэтгэн, олонхийн саналаар шийдвэр гаргах тогтолцоо юм.

Өнөөгийн байдлаар бичил уурхайн дэд салбарыг дэмжиж ТоБУТөсөл нь хүлээгдэж буй үр дүн 2 “Бичил уурхайг бүх түвшинд бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг сайжруулсан байх ” зорилтын хүрээнд дараах чиглэлээр хувиараа ашигт малтмал олборлогчдын үүсгэл санаачлагын байгууллагуудтай идэвхитэй ажиллаж байгаа ажээ. Үүнд:

- Төв аймгийн Борнуур сумын Бичил уурхайчдын холбоо/ТББ нь орон нутгийн хэмжээнд олон нийтийг дайчлах, идэвхижүүлэх, мөнгөн усгүй технологи нэвтрүүлэх чиглэлээр ТоБУТ-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж байна.
- Баянхонгор аймгийн Жаргалант сумын “Байдрагийн хөгжил” ТББ нь орон нутгийн хэмжээнд ТоБУТ-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, олон нийтийг дайчлах, байгаль орчинд ээлтэй, үр ашигтай технологи нэвтрүүлэх, одоогийн хэрэглэж буй техник технологийг сайжруулах талаар хамтран ажиллаж байна.
- Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Дууш Мандал хайрхан” ТББ нь орон нутгийн хэмжээнд олон нийтийг дайчлах, мөнгөн усгүй технологийг нэвтрүүлэх чиглэлээр ТоБУТ-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж байна.
- Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын “Баян Бөмбөгөр” бичил уурхай эрхлэгчдийн ТББ нь олон нийтийг дайчлах, идэвхижүүлэх байгаль орчинд ээлтэй, үр ашигтай технологи нэвтрүүлэх, одоогийн хэрэгжүүлж буй техник технологийг сайжруулах чиглэлээр хамтран ажиллаж байна.

Есдүгээр бүлэг. Орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд бичил уурхайн оруулж буй хувь нэмэр



Орон нутагт хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд ядуурлыг бууруулахад чиглүүлэн ашиглаж чадваас жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний бизнесийг дэмжиж, олон тооны ажлын байр шинээр бий болгох, бэлэн мөнгөний эргэлтийг нэмэгдүүлэх зэргээр хөдөөгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах асар их нөөц боломж гарч ирнэ.

Хэдийгээр хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд нийгэм таагүйгээр ханддаг боловч орон нутгийн хөгжилд тэдгээр хүмүүсийн оруулж байгаа хувь нэмэр, оролцоог сайн олж

харж чаддаггүй нь харамсалтай. Энэ нь нэн тэргүүнд хувиараа ашигт малтмал олборлохтой холбоотой зөрчил маргаан, байгаль орчны бохирдол, хүмүүсийн ухамсар, зан авир, ашигт малтмал олборлосон газрын эвдрэл зэрэг нь нийгэмд маш таагүй сэтгэгдэл төрүүлдэгтэй холбоотой байж болох юм.

Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанаас орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмэрийг суурь судалгаа явагдсан сумдын түвшинд авч үзэн харуулахыг бид зорьсон болно.

Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанаас орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр	
Баянхонгор аймгийн Жаргалант сум	Төв аймгийн Борнуур сум
- Жаргалант сумын хувиараа ашигт малтмал олборлогч 314 иргэн 37 бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж, сумын засаг даргатай гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулаад 2 жил болсон - Тэдгээр иргэний гэр бүлийн гишүүд болох 1400 гаруй хүний амьдрал бичил уурхайгаас шууд хамааралтай байгаа бөгөөд 2009 оны 7-8 сарын байдлаар тус сумын нийт өрхийн 80 гаруй хувийн хэн нэгэн төлөөлөл алт олборлож өрхийн амьжиргаандаа хувь нэмэр оруулж байжээ. - Хувиараа ашигт малтмал олборлогч нэг иргэний сарын дундаж орлого 286 875 төгрөг гэж үзвэл тус сумын нийт ХАМО иргэд сард 90,07 сая төгрөг, жилд 1,08 тэрбум төгрөгийн орлого олдог. - Нийт ХАМО иргэдийн 4 хувь нь 1 жилд ХАОАТ-т 4,3 сая төгрөг төлсөн. - ХАМО иргэдийн 37,4 хувь нь нийгмийн даатгалд, 84,2 хувь нь ЭМД-д хамрагдаж байна. - Хувиараа ашигт малтмал олборлогчид 2,7 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн.	- Борнуур сумын хувиараа ашигт малтмал олборлогч 196 иргэн 65 бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтанд орсон. - Тэдгээр иргэдийн гэр бүлийн гишүүд болох 900 гаруй хүний аж амьдрал бичил уурхайгаас хамааралтай. - Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үүсгэн байгуулсан ХАМО ХХК нь мөнгөн усгүй технологи бүхий “Төвийн бүсэд алтны хүдэр баяжуулах цех”-ийг байгуулан ашиглалтанд оруулж, байнгын 61 ажлын байрыг шинээр бий болгон орон нутгийн төсөвт оруулах орлогын хэмжээ нь жил ирэх бүр өсөн нэмэгдэж байна. - Уг цех ашиглалтанд орсноор Борнуур сум болон хөрш, ойролцоо сумдын хувиараа ашигт малтмал олборлогчдын амьжиргааны тогтвортой байдлыг баталгаажуулсан. - Нийт хувиараа ашигт малтмал олборлогчдын 10,0 хувь нь жилд ХАОАТ-т 6,7 сая төгрөг төлж байна. - ХАМО иргэдийн 26,0 хувь нь нийгмийн даатгалд, 65,0 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагджээ.

ХАМО ХХК нь 2009 оны байдлаар 60 гаруй ажилчидтай, орон нутгийн төсөвт ХАОАТ, ЭМД, НДШ болон орлогын албан татвар хэлбэрээр 16,5 сая гаруй төгрөг, 2010 оны 9 дүгээр сарын байдлаар НӨАТ, ХАОАТ, ЭМД, НДШ хэлбэрээр 72,5 сая төгрөгийг оруулж орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулж байна..

Зөвхөн Борнуур сумын хэмжээнд авч үзэхэд сүүлийн 5 жилийн хугацаанд тус сумын айл өрх, хүн амын тоо жил дараалан буурч байсан бол ХАМО ХХК-ийн хүдэр баяжуулах цех ашиглалтанд орсноор хүн амын тоо өсөх хандлагатай болсон. Энэ хандлага нь хот руу ажил хайж явсан уугуул иргэд болон бусад хүмүүс үйлдвэрлэл үйлчилгээний болон алт олборлох бизнес эрхлэхээр энд шилжин ирсэнтэй холбоотой юм. Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулахад бага ч

гэсэн хувь нэмэр оруулж хөдөө орон нутагт шинээр ажлын байр бий болгон, иргэд амьдарч буй орон нутагтаа ажил эрхлэн амьдрах боломжийг дээшлүүлж өгсөн гэж дүгнэж байна.

Дээр дурдсан хэдхэн жишээгээр хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанаас орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг үнэлбээс хэтэрхий өрөөсгөл талтай байж болох ч хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанаас тодорхой ашиг хүртэж, хуримтлал бий болгосон иргэд мал аж ахуй эрхлэх, дэлгүүр хоршоо ажиллуулах, газар тариалан эрхлэх болон өөр жижиг дунд бизнесийн үйл ажиллагаанд шилжиж байгаа нь бодит үр дүн юм.

Нөгөө талаар хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа нь хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд явагдсанаар Монгол улсын эрдэнэсийн сан болоод гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд тодорхой хэмжээний хувь нэмэр оруулж байгаа нь ойлгомжтой билээ.

Аравдугаар бүлэг. Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа ба байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл

10.1. Байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл.

“Хөгжих эрхийг хэрэгжүүлэхдээ өнөө ба хойч үеийнхний хөгжлийн болон хүрээлэн буй орчны талаархи хэрэгцээг зохистой хангасан байх ёстой. Тогтвортой хөгжилд хүрэхийн тулд хүрээлэн буй орчныг хамгаалах нь хөгжлийн үйл явцын салшгүй хэсэг болох ёстой бөгөөд түүнээс салган үзэж болохгүй. (” Рио-Де-Жанейрогийн хүрээлэн буй орчин ба хөгжлийн тунхаглал”-аас)

Монгол Улсад сүүлийн жилүүдэд ган зуд, хүчтэй цасан болон шороон шуурга, үер, түймэр, хортон шавьж, мэргэгчдийн хөнөөл зэрэг байгалийн гамшигт үзэгдэл олонтоо тохиолдож, хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд ихээхэн хохирол учруулж байгаагаас гадна уул уурхайн үйлдвэрлэлийн хариуцлагагүй үйл ажиллагаа нь цөлжилт эрчимжих шалтгаануудын нэг болж байна.

Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа нь олон мянган хүмүүсийн амьжиргааг дээшлүүлэх, ажлын байраар хангах, амьдралын чанарыг сайжруулах замаар орон нутгийн тогтвортой хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулж байгаа боловч байгаль экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөө үзүүлэн байгалийн унаган төрхийг дахин сэргэхээргүйгээр эвдэж сүйтгэж буй нь гашуун боловч үнэн юм.

Үзүүлэлт	Бигэр сум	Борнуур сум	Жаргалант сум	Уянга сум
Байгаль орчин, хүний биед сөрөг нөлөө бүхий химийн бодис ашиглалт	0	0	0	0
ХАМО иргэдээс байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл	их	бага	бага	их

Эх сурвалж: Нийгэм эдийн засгийн суурь судалгаа

Дээрх судалгааны мэдээллээс үзэхэд Говь-Алтай аймгийн Бигэр, Өвөрхангай аймгийн Уянга суманд алт олборлох чиглэлээр ажиллаж буй хувиараа ашигт малтмал олборлогч иргэдээс байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл нь чанарын хэмжигдэхүүний үзүүлэлтээр их гэж гарсан байна.

Ашигт малтмалыг бусдаас өрсөн олж авахын тулд хаа хамаагүй ухаж сэндийлсэн газрын эвдрэл, ахуйн хог хаягдал, малын бэлчээрийн доройтол болон ухаж төнхөөд нөхөн сэргээлт хийлгүй орхисон нүх, шуудуунд хүн, мал амьтан унаж, гэмтэж бэртэх, мод, бут сөөгийг түлшинд хайр гамгүй хэрэглэх, хөрс ургамлыг үндсээр нь сүйтгэх зэрэг нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж буй гол шалтгаанууд мөн гэж судалгааны явцад тодорхойлжээ. Мөн дээрх газруудад гэмт хэрэг, зөрчил гардаг болохыг ч дурдсан байгаагаас гадна хувиараа ашигт малтмал олборлогч

иргэдийн хооронд болон бусад талуудын хооронд гардаг зөрчил маргаан их байна гэж дүгнэсэн. Зөрчил маргаан олон удаа гардаг шалтгаан нь ашиг хуваарилалт, тоног төхөөрөмж ашиглалт, түрээс, хөдөлмөрийн хуваарь, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талбайд хулгайгаар олборлолт явуулах зэргээс үүдэлтэй байдаг ажээ.

Харин байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөлөл, талуудын хоорондох зөрчил маргаан зэрэг нь “Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын хүрээнд үйл ажиллагаа явуулж байсан Баянхонгор аймгийн Жаргалант, Төв аймгийн Борнуур сумын хувиараа ашигт малтмал олборлогчдын дунд маш бага байгаа нь судалгаанаас харагдаж байна. Энэ амжилт нь хувиараа ашигт малтмал олборлогчдын бүтэц, зохион байгуулалт, нийгмийн өмнө хүлээх хариуцлагаа ухамсарласан байдал, тэдгээрт ТоБУТ-ийн үзүүлсэн нааштай үр нөлөө гэж үзэх боломжтой юм.

Сүүлийн жилүүдэд уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор хөрсний эвдрэл, бэлчээр усны хомсдол, бохирдол зэрэг байгаль орчны асуудал маш хурцаар тавигдаж, орон нутгийн иргэдийн эрх ашиг ноцтой зөрчигдөхөд хүрсэн. Уул уурхайн салбарын дэд хэсэг болох бичил уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг хувиараа ашигт малтмал олборлогчид хариуцлагатай байхын тулд үйл ажиллагаа нь албан ёсны, нийгэмд тустай, эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэй байх ёстой.

Зарим тоо баримт, мэдээлэл.

Уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй явагдсан цагаас хойш Монгол Улсын хэмжээнд 14 мянга 565 га газрыг эвдрэлд оруулжээ. Үүнээс хувиараа ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагаанаас 1000 гаруй га газар эвдрэлд өртсөн тухай судалгаа гарсан. 2008 он хүртэлх хугацаанд 3386,6 га газарт уул уурхайн олборлолт явуулсан аж ахуйн нэгжүүд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийсэн ба харин 10 мянга гаруй га газарт нөхөн сэргээлт огт хийгдээгүй болохыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2008 оны тайланд дурджээ.	
• БОАЖЯ 2009, 2010 онд жонш болон үнэт, хагас үнэт чулууны уурхайн олборлолтонд өртөөд нөхөн сэргээгдээгүй хаясан газрын тооллогыг хийж байна. • Мөн цэргийн болон бусад зориулалтаар газрын хэвлийг хөндөөд нөхөн сэргээлгүй хаясан талбайг тоолох юм байна. • Урьдчилсан байдлаар Дорноговь аймгийн таван суманд 29,012 га, Дундговь аймгийн зургаан сумын нутаг дахь 20 гаруй газарт 176,98 га, Хэнтийд 39 газарт 402,2 га газрыг нөхөн сэргээлгүй орхисон мэдээ байгаа аж. • БОАЖ-ын сайдын тушаалаар нөхөн сэргээлтийн нөхөн төлбөр төлөх аргачлал батлагдсан. Байгаль орчны тухай хуульд зааснаар газрын нөхөн төлбөрийн асуудлын нэхэмжлэгч нь орон нутгийн Засаг дарга нар байх юм. • Өнөөдрийн аргачлалаар бол үнэлгээг газрын доорх баялгаас гадна амьтан, ургамал, ус гэх мэтээр экосистемийн бүх зүйлийг	• Хувиараа ашигт малтмал олборлогчид алт олборлох үйл ажиллагааг эхлүүлснээс хойш нийгэмд эерэг, сөрөг олон үр дагавруудыг бий болгосны нэг нь алтны үндсэн ордтой холбоотой мөнгөн усны хэрэглээ байсан юм. • Алтны үндсэн ордод химийн хорт бодис, ялангуяа мөнгөн усыг их хэмжээгээр хэрэглэж, хадгалах, тээвэрлэх горимыг алдах, ахуйн нөхцөлд алт бариулж, барьсан алтаа ууршуулах замаар цэвэршүүлж байсан. • 2007 онд Ерөнхий сайдын үүрэг болгосны дагуу Улсын мэргэжлийн хяналтын газраас химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн үзлэг шалгалтаар улсын хэмжээнд нийт 147 тээрмийг хурааж устгажээ. • Өнөөдөр улсын хэмжээнд хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд мөнгөн ус, цианит натри зэрэг химийн бодисын


оруулж тооцох ёстой юм байна.

хэрэглээ эрс буурсан.

Монгол Улсын Засгийн газраас байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ 2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр 7700,3 сая төгрөгт хүрч, өмнөх оныхоос 307,9 сая төгрөг буюу 4,2 хувиар нэмэгдсэн байна. Үүнээс:

- Байгаль хамгаалах санд 3,4 хувь
- Байгаль орчны төвлөрсөн арга хэмжээнд 9,1 хувь
- Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтанд 24,6 хувь
- Ойжуулахад 29,8 хувь
- Байгаль орчны алба, байгаль хамгаалагчдын үйл ажиллагаанд 33,1 хувийг зарцуулжээ.

Хохирол учирсан газар



Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхтгэл 2009 он

Манай орны уул уурхайн салбарт хохирол учирсан газрын хэмжээ 2009 оны байдлаар нийт 65,3 мян га –д хүрээд байгаагаас ухах эвдрэлд оруулсан газар 45,7 мян. га, геологийн эрэл хайгуулын ажлаас үүдэлтэйгээр эвдэрсэн 2,7 мян га, ашигт малтмал олборлолтоос шалтгаалан эвдрэлд орсон 16,9 мян га газар байжээ.

10.2.Хувиараа ашигт малтмал олборлолт ба нөхөн сэргээлт.

Хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанаас үүссэн байгаль орчин, газрын эвдрэл түүнийг нөхөн сэргээх асуудлыг хэн хариуцах вэ гэдэг асуулт байнга тавигдаж ирсэн. Энэхүү асуудлыг Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар:

- тусгай зөвшөөрөл эзэмшигчид олгогдсон газарт хууль бусаар ашигт малтмал олборлоод нөхөн сэргээлгүй хаясан бол тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчид,
- орон нутгийн тусгай хэрэгцээний газар буюу бусад хэрэгцээний газруудад хууль бусаар ашигт малтмал олборлосон тохиолдолд орон нутгийн засаг захиргаа нөхөн сэргээлтийн асуудлыг хариуцахаар 2 ангилж үзэж байна.

Ашигт малтмал олборлосон газарт эхлээд техникийн, дараа нь биологийн нөхөн сэргээлт хийх шаардлагатай байдаг.

Орон нутагт хувиараа ашигт малтмал олборлогчид байгаль орчин, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ орхигдуулж, холбогдох хууль, тогтоомжуудыг үл хүндэтгэн ашигт малтмал олборлосон газрыг нөхөн сэргээлгүй хаях тохиолдол түгээмэл байна.

Хэдийгээр дээр өгүүлсэн сөрөг үзэгдлүүд хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд байгаа боловч, хувиараа ашигт малтмал олборлогчдын сэтгэлгээнд эерэг өөрчлөлт орж, өөрсдийн хүч, нөөц боломжийн түвшинд уул уурхайн нөхөн сэргээлт хийж хэвших шинэ хандлага, санаачлага бас бий болж байна.

Тухайлбал, Швейцарийн хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төсөл Монгол Улсад хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэх талаар холбогдох талуудтай хамтран ажиллаж, бичил уурхай эрхлэгчдийг хөдөөгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах эдийн засгийн дэд салбарын хариуцлагатай гишүүд болгоход хувь нэмрээ оруулах зорилгоор үйл ажиллагаа явуулаад багагүй хугацаа өнгөрсөн байна.

2010 оныг хүртэлх хугацаанд тус төсөл Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Жаргалант, Төв аймгийн Борнуур, Сэлэнгэ аймгийн Мандал сумдын хувиараа ашигт малтмал олборлогчдыг зорилтот хэсгээр сонгон авч үйл ажиллагаа явуулжээ.

Төслийн “Бичил уурхай эрхлэгчид ба бусад нөөц ашиглагчдыг байгаль экологи, нийгмийн асуудалд хариуцлагатай хандаж, гарч буй зөрчлийг шийдэж чаддаг чадвартай болгох” бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Баянхонгор аймгийн Жаргалант сумын хувиараа ашигт малтмал олборлогчдын үүсгэл санаачлагаар байгуулагдсан “Байдрагийн хөгжил”, Бөмбөгөр сумын “Баян Бөмбөгөр” бичил уурхай эрхлэгчдийн төрийн бус байгууллагуудтай олон нийтийг дайчлах, идэвхижүүлэх, байгаль орчинд ээлтэй үр ашигтай технологи нэвтрүүлэх, одоогийн олборлох, баяжуулах үйл ажиллагаанд ашиглаж буй техник технологийг сайжруулах талаар хамтран ажиллаж иржээ.

Дээр дурдсан сумдын хувиараа ашигт малтмал олборлогчдын эрх ашгийг хамгаалах, тэдэнд дэмжлэг үзүүлэх чиглэл бүхий төрийн бус байгууллагууд нь өөрсдийн гишүүн, хувиараа ашигт малтмал олборлогчдын хүн, хүч, техник, тоног төхөөрөмжийн нөөцөд тулгуурлан 2009-2010 оны хооронд нийт 10,1 га газарт техникийн нөхөн сэргээлт хийжээ. Нөхөн сэргээлтийг ТоБУТ-ийн техникийн багийн технологийн зөвлөх үйлчилгээний тусламжтайгаар хийж гүйцэтгэн сум, орон нутгийн засаг захиргаанд хүлээлгэн өгчээ.



	Аймаг, сумын нэр	Газрын нэр	Нөхөн сэргээлт хийсэн талбай /га/	
			2009 он	2010 он
1	Баянхонгор аймаг. Бөмбөгөр сум	Буйлсан	4,9	2,5
2	Баянхонгор аймаг. Жаргалант сум	Баруун, зүүн салаа	1,2	1,5
	Дүн		6,1	4,0
	Нийт дүн		10,1	

Алтны шороон ордод олборлолтоос шалтгаалан эвдэрсэн газрыг нөхөн сэргээх үйл ажиллагааг Швейцарийн хөгжлийн агентлагийн ТоБУТ-ийн дэмжлэгтэйгээр амжилттай хэрэгжүүлсэн нь орон нутагт хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэхэд томоохон ахиц дэвшил авчирсан гэж үнэлж байна.

Арваннэгдүгээр бүлэг. Хувиараа ашигт малтмал олборлогчдын хөгжил, цаашдын чиг хандлага.

Дэлхийн хэмжээнд эрдэс баялгийн түүхий эдийн эрэлт, хэрэгцээ өсч , ашигт малтмалын олборлох, боловсруулах үйлдвэрүүд олшрохын зэрэгцээ , ашигт малтмалын нөөцийн хэмжээ улам бүр хомсдож байгаа нөхцөлд түүнийг бүрэн гүйцэд ашиглах шаардлага улс орон бүрт тулгарч байгаа билээ.

Монгол Улсад ашигт малтмалыг хувиараа олборлох үйл ажиллагаа нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг бүхий социалист систем задарч, зах зээлийн харилцаанд шилжиж эхэлсэн он жилүүдэд ажилгүйдэл, мөнгөний ханшны уналт, хүн амын бодит орлогын бууралт зэрэг эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн сөрөг үр дагаварын мөрөөр бий болсон үзэгдэл юм.

Ажилгүйдэл, ядуурлын түвшин орон нутагт мэдэгдэхүйц буурахгүй байгаа учраас ашигт малтмалыг хувиараа олборлогчид олширч, эрдэс баялгийн нөөцийг үрэлгэн, үр ашиггүй ашиглаж, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь ихсэж эхэлсэн тул ашигт малтмалын нөөцийн ашиглалтыг сайжруулахад хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зөв зохицуулах асуудал хурцаар тавигдаж эхэлсэн билээ.

Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 72 дугаар тогтоолоор “Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ыг баталсан. Энэхүү журмыг баталж гаргаснаар хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа бичил уурхайн дэд салбарын хэмжээнд хүрсэнийг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн бөгөөд мөн Засгийн газрын 71 дүгээр тогтоолоор “Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг батлан гаргасанаар хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааны хөгжил шинэ шатанд гарч ирсэн гэж үзэж болох юм.

Нөгөө талаас авч үзвэл “Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам” батлагдсанаар хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа эрхлэх анхны эрх зүйн орчин бүрдэж, орон нутгийн засаг захиргааны зүгээс энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэдэд хандах хандлага өөрчлөгдөн, анхаарал тавьж эхэлсэн нь эхний ололт амжилт байлаа.

Төв аймгийн Борнуур суманд хувиараа ашигт малтмал олборлогчид 2007 онд анх “Бичил уурхайчдын холбоо” төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулж, өөрсдийн эрх ашгийг хамгаалах талаар идэвхитэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн нь амжилтанд хүрч мөнгөн усгүй технологи бүхий “Алтны үндсэн ордын хүдэр баяжуулах цех” байгуулах үүсгэл санаачлага нь төрөөс дэмжлэг авсанаар Монгол Улсад бичил уурхайн дэд салбарыг хөгжүүлэхэд томоохон түлхэц өгсөн эхлэл болжээ.

Энэхүү хүдэр баяжуулах цех байгуулахтай холбоотойгоор түр журмын хүрээнд хувиараа ашигт малтмал олборлогчдоор гишүүнчлэгдсэн анхны бүртгэгдээгүй нөхөрлөлүүд байгуулагдах алхамууд хийгдэж эхлэснээр өнөөдөр Монгол Улсын хэмжээнд 410 гаруй бүртгэгдээгүй нөхөрлөлүүд, тэдгээрийн сайн дурын гишүүнчлэл бүхий 10 гаруй төрийн бус байгууллага үйл ажиллагаагаа идэвхитэй явуулж байна. Бүртгэгдээгүй нөхөрлөлүүдийн гишүүд болох хувиараа ашигт малтмал олборлогч иргэд тухайн орон нутагт бүртгэлтэй болж, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдсанаар төрийн халамж, үйлчилгээ хүртэх, нийгмийн асуудлаа шийдвэрлүүлэх боломж нээгдсэн. Бүртгэгдээгүй нөхөрлөлүүд орон нутгийн засаг даргатай гэрээ байгуулан хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж орон нутгийнхаа байгалийн баялаг, нөөцийг ашиглаж байгаагийнхаа төлөө тодорхой хариуцлага хүлээх, байгаль орчноо нөхөн сэргээх, хамгаалах болон нийгмийн салбарт хөрөнгө оруулах санаачлага гарган эхний алхмуудаа хийж эхэлсэн байна.

Бичил уурхайн дэд салбарын хөгжлийн энэхүү амжилт нь Швейцарийн хөгжлийн агентлагаас “Тогтвортой бичил уурхай” төслийн хүрээнд идэвхитэй, үе шаттай хэрэгжүүлж ирсэн үйл ажиллагаатай нягт уялдаатай билээ. Үүний үрээр бичил уурхайн салбарт хөгжил дэвшил гарч, бүртгэгдээгүй нөхөрлөлүүд, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагууд үүсэн буй болж, улмаар төлөвших шат руугаа явж байна.

Бичил уурхайн салбарын нөхцөл байдлын шинжилгээ:

Дотоод орчин	
Давуу тал	Сул тал
- Олон жил хувиараа ашигт малтмал олборлож байгаа туршлага бүхий хүний нөөц - Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж, нийгмийн хариуцлагатай гишүүд болох хүсэл эрмэлзэл - Бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтаар ажиллаж байгаа хувиараа ашигт малтмал олборлогчид ХАОАТ, НДШ, ЭМД зэрэгт хамрагдсан байдлын хувь хэмжээ жил бүр өсөн нэмэгдэж байгаа - Тодорхой хуримтлал бий болгосон хувиараа ашигт малтмал олборлогчид орон нутагт жижиг бизнесийг шинээр эхлүүлж, ажлын байр бий болгож байна. 2007 онд анх Төв аймгийн Борнуур суманд	- Хувиараа ашигт малтмал олборлогчдын сэтгэлгээний хоцрогдол - харилцаа холбоо, үр дүнтэй хамтын ажиллагаа сул хөгжсөн - Хүрээлэн байгаа байгаль орчныг доройтуулж, нийгмийн бүлгүүдийн эрх ашгийг хөндсөн хариуцлагагүй үйл ажиллагаатай холбоотой зөрчил, маргаан их - Бичил уурхайн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг хангах талаар орон нутгийн засаг захиргаа, хувиараа ашигт малтмал олборлогчид идэвхи санаачлага бага гаргаж байгаа - Хувиараа ашигт малтмал олборлогч иргэд бичил уурхайн эрх зүйн зохицуулалтын талаар мэдээлэл, мэдлэг, ойлголт муутай - Орон нутгийн засаг захиргаа, тусгай

хувиараа ашигт малтмал олборлогчид “Бичил уурхайчдын холбоо” төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулж, өөрсдийн эрх ашгийг хамгаалах талаар идэвхитэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Монгол улсын Засгийн газрын 28 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд байгуулагдсан Баянхонгор аймгийн Баян-Овоо, Төв аймгийн Борнуур сумын мөнгөн усгүй технологи бүхий “Алтны хүдэр баяжуулах” цехүүдийн туршлага, орон нутгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр	зөвшөөрөл эзэмшигчид, хувиараа ашигт малтмал олборлогчдын хоорондын харилцан ойлголцол, хамтын ажиллагаа сайн хөгжөөгүй - Хувиараа ашигт малтмал олборлогчдын хөдөлмөрийн бүтээмж бага, технологи хоцрогдсон - Бичил уурхайд ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны мэдлэг, ойлголт, ур чадвар хангалтгүй - Хувиараа ашигт малтмал олборлогчдыг үндэсний хэмжээнд төлөөлөх, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах байгууллага байхгүй - Алтны хууль бус борлуулалт
Гадаад орчин	
Боломж	Аюул
- УИХ-аас баталсан “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, “Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай” хууль - Монгол улсын Засгийн газрын “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулах журам” - Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр - Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр - Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан - Бичил уурхайн салбарт хэрэгжиж байгаа Швейцарийн хөгжлийн агентлагын “Тогтвортой бичил уурхай” төсөл	- Засгийн газрын зүгээс бичил уурхайн талаар баримтлаж байгаа бодлого чиглэл өөрчлөгдөх - Байгалийн эрдэс баялгийн нөөц багасах, дуусах, ашигт малтмалын бүтээгдэхүүний хууль бус худалдаа - Хувиараа ашигт малтмал олборлогчдын нийгмийн хариуцлагагүй үйл ажиллагаатай холбоотойгоор нийгмийн бүлгүүдийн зүгээс дургүйцэх, эсэргүүцэх хандлага хүчтэй болох - Ашигт малтмалын түүхий эд, бүтээгдэхүүний үнэ ханш дэлхийн зах зээл дээр огцом буурах

Бичил уурхайн дэд салбарын тогтвортой хөгжлийг хангахын тулд давуу талаа ашиглан сул талаа засч сайжруулах, давуу тал, боломжууддаа түшиглэн аюул заналаас урьдчилан сэргийлэх бодлого, арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Салбарын хэмжээнд авч үзэн давуу талдаа дулдуйдан сул талыг сайжруулах, давуу тал, боломжуудад түшиглэн аюулаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодлого, зорилтуудад хэрэгжүүлэх нь бичил уурхайн салбарын цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох болно.

Бичил уурхайн салбарын дотоод орчны давуу талыг ашиглан сул талыг сайжруулах бодлого, зорилтууд:

- Бичил уурхайн хууль эрх зүйн зохицуулалтын талаарх мэдлэг, мэдээллийг нийт хувиараа ашигт малтмал олборлогчдод түгээн дэлгэрүүлэх
- Идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа хувиараа ашигт малтмал олборлогч иргэдээр гишүүнчлэгдсэн төрийн бус байгууллагууд сэдэл, санаачлага гарган үндэсний хэмжээнд тэдгээрийг төлөөлөх, эрх ашгийг нь хамгаалах, дэд салбарын хөгжлийн бодлогыг тодорхойлон төр захиргааны байгууллагуудтай холбох чиг үүрэг бүхий дээвэр байгууллага байгуулах
- Хувиараа ашигт малтмал олборлогчид нийгмийн өмнө хүлээсэн үүргээ хариуцлагатай биелүүлэх сэтгэхүйг төлөвшүүлэх үйл ажиллагааг орон нутгийн засаг, захиргаа болон бүртгэгдээгүй нөхөрлөлүүд, төрийн бус байгууллагууд хамтран үе шаттайгаар зохион байгуулж хэрэгжүүлэх

- Татвар, нийгмийн даатгалын асуудал хариуцсан орон нутгийн ажилтнууд өөрсдийн үйл ажиллагааг хувиараа ашигт малтмал олборлогчдод таниулах сургалт, сурталчилгааг зохион байгуулж татварын бааз суурийг өргөжүүлэх
- Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Жаргалант, Төв аймгийн Борнуур сумын бүртгэгдээгүй нөхөрлөлүүд болон тэдгээрийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагууд өөрсдийн туршлага, сургамжуудыг бусдад түгээн дэлгэрүүлэх талаар санаачлага гаргах.
- Бичил уурхайг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ төрийн зарим чиг үүргийг бичил уурхайн салбарын төрийн бус байгууллагуудаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх
- Хувиараа ашигт малтмал олборлогчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны мэдлэг, ойлголт, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор орон нутгийн засаг захиргаа ашигт малтмал олборлох талаар техникийн сургалтуудыг явуулсаны дараагаар гэрээ байгуулах.
- Бичил уурхайд ажиллах боловсон хүчнийг мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд сургаж бэлтгэх
- Төрийн байгууллагууд, хувиараа ашигт малтмал олборлогчдын эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагууд хамтран бичил уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн стандарт, техникийн шаардлагуудыг шинэчлэх, шинээр боловсруулж батлуулан мөрдүүлэх
- Урт хугацаанд эдийн засгийн өсөлт авчрах орон нутгийн дэд салбаруудыг хөгжүүлэхэд бичил уурхайн бодит нөөц боломжуудыг ашиглах бодлогыг орон нутгийн засаг захиргаа боловсруулан хэрэгжүүлэн хувиараа ашигт малтмал олборлогчдыг аажмаар өөр салбарт шилжүүлэн хуулийн этгээдийн зохион байгуулалтаар ажиллах урьдчилсан нөхцөлүүдийг бүрдүүлэх.

Бичил уурхайд гадаад орчны зүгээс үзүүлж байгаа боломжуудыг ашиглан аюулаас урьчилан сэргийлэх бодлого, зорилтууд:

- Бүртгэгдээгүй нөхөрлөлүүдийн үйлдвэрлэлийн технологийг сайжруулан гоёл чимэглэл, үнэт эдлэл, бэлэг дурсгалын бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэл рүү шилжүүлэх
- Ашигт малтмал олборлосон бол нөхөн сэргээлтийг технологийн дагуу хийдэг сэтгэлгээг хувиараа ашигт малтмал олборлогчдод төлөвшүүлэн хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэх
- Бичил уурхайг дэмжиж гурвалсан гэрээгээр ажиллаж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг татварын болон бусад хөнгөлөлт, урамшууллаар дэмжих тогтолцоог бий болгох
- Хувиараа ашигт малтмал олборлогчдын олборлосон бүтээгдэхүүний борлуулалтын нэгдсэн сүлжээг бий болгох
- Хувиараа ашигт малтмал олборлогчдын олборлосон бүтээгдэхүүний эрдэс баялгийн гарал үүслийн гэрчилгээжүүлэлт, баталгаажуулалтын тогтолцоог бий болгон хууль ёсны худалдааг дэмжих
- Сорьцын хяналтын улсын албаны Үнэт металлын сорьц тогтоох лабораторийн үйл ажиллагааг уян хатан, нээлттэй болгох замаар орон нутагт салбарыг нь байгуулахад төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх.
- Хувиараа ашигт малтмал олборлогчид олноор төвлөрсөн аймгуудын ЗДТГ-ын дэргэд бичил уурхайн асуудал хариуцсан бүтцийг бий болгох, тэдгээрийн чадавхийг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлэх
- Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийг нийгмийн үйлчилгээнд тэгш, хүртээмжтэй хамрагдах нөхцөл боломжуудыг нээж өгөх.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ

1. **Монгол Улсын Статистикийн эмхэтгэл**
Үндэсний Статистикийн газар, УБ хот, 2008, 2009 он
2. **Төв аймгийн хүн ам, нийгэм, эдийн засгийн мэдээлэл, Аймгийн Статистикийн алба,**
Зуунмод, 2009 он.
3. **Төв аймгийн Борнуур, Баянхонгор аймгийн Жаргалант, Өвөрхангай аймгийн Уянга, Говь-Алтай аймгийн Бигэр сумын нийгэм эдийн засгийн суурь судалгаа.**
2009-2010 он
4. **Бичил уурхай, хэтийн төлөв, зохицуулалт**
ТоБУ төсөл, ШХА, УБ, 2008
5. **Олон улсын туршлагаас товч танилцуулах нь**
М. Приестэр (орчуулга), ШХА, УБ, 2005
6. **Монголын хувиараа ашигт малтмал олборлогчдын техник, технологийн үнэлгээ**
ТоБУ төсөл, ШХА, УБ, 2007 он
7. **Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, заавар**
ТоБУ төсөл, ШХА, УБ, 2009
8. **Нинжа нарын нэн шинэ түүх**
ТоБУ төсөл, ШХА, УБ, 2009 он
9. **“Бичил уурхай ба хөдөөгийн хөгжил” үндэсний зөвлөгөөн**
ТоБУ, ШХА, УБ, 2009 он
10. **Та эрхээ хамгаалж чадах уу.**
Иргэдэд зориулсан гарын авлага. Хүний эрх хөгжил төв. 2007 он
11. **Байгалийн нөөцийн ашиглалт, тогтвортой амьжиргаа.**
Олон нийтэд зориулсан гарын авлага. МХСМТ. 2010 он

А5-ийн хэмжээтэй.